



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP

МОНГОЛ ХЭЛ IV ГАРЫН АВЛАГА



Улаанбаатар хот
2023 он

Ж.ГЭРЭЛМАА, А.ЕРКЕГҮЛ, З.ЖАНАРГҮЛ, Б.ГҮЛЖАН

МОНГОЛ ХЭЛ IV

ГАРЫН АВЛАГА

Хос хэлний сургалттай Ерөнхий Боловсролын Сургуулийн
4 дүгээр ангид судална.

Улаанбаатар хот
2023 он

ННА
ДДА

Монгол хэл IV: Хос хэлний сургалттай Ерөнхий Боловсролын сургуулийн 4
дүгээр ангийн гарын авлага

/УБ. 2023.-76х- /

ЗОХИОГЧИЙН БАГИЙН АХЛАГЧ:

Ж. Гэрэлмаа

ЗОХИОГЧИЙН БАГИЙН ГИШҮҮД

А. Еркегүл

З. Жанаргүл

Б. Гүлжан

РЕДАКТОР:

Д. Эрдэнэсан

Х. Солтанмурат

Энэхүү гарын авлагыг Боловсрол, шинжлэх ухааны яам, Дэлхийн банкны хамтран хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн дэмжлэгээр боловсруулж, хэвлэв

© Боловсрол, Шинжлэх Ухааны Яам

ISBN: 978-

ГАРЧИГ

ЗУНЫ ЗУГААТАЙ ӨДРҮҮД	4
БИ	9
ГЭР БҮЛ	21
СУРГУУЛЬ	30
АЖИЛ ХӨДӨЛМӨР	41
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН	51
ЭРҮҮЛ АМЬДРАЛ	61
АМЬТАД	71
БАЙГАЛЬ ДЭЛХИЙ	83
ХУВЦАСЛАЛТ, ХУВИЙН СОЁЛ	94
УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШИЛ	105
ДАВТЛАГА	116

ТАНИХ ТЭМДЭГ



СОНСОХ



БИЧИХ



УНШИХ



ХАРИУЛАХ



ЯРИХ



ЗУРАХ



ОЛОХ



А. Хүүхдүүд зуны амралтаа хэрхэн өнгөрүүлснийг уншаад асуултад хариулж бичээрэй.

Туяа:

Би зун амрах дуртай. Бид гэр бүлээрээ хөдөө амарсан. Усанд сэлж, ой модоор зугаалж, хөл бөмбөг, гар бөмбөг тоглосон. Байгальд үнэхээр сайхан амарлаа.



Од:

Би зуны амралтаараа зусланд амарлаа. Надад маш их таалагдсан. Би олон найзуудтай болсон. Бид өглөө дасгал хийж, өдөр дуулж, орой бүжиглэдэг байв. Зусланд өнгөрүүлсэн өдрүүд их хөгжилтэй байсан шүү.



Туул:

Би зун гэртээ, аймгийн төвд байсан. Би өдөр болгон найзуудтайгаа уулзаж, сагс тоглож, дугуй унаж, хөгжим сонсдог байв.



Эгшиглэн:

Энэ зун би гэрийнхэнтэйгээ Толбо нуурын эрэгт амарсан. Бид амралтаа сайхан өнгөрүүлэв. Тэнд усанд сэлж, ширээний теннис тоглож сурлаа.



Бат:

Манайх малчин айл. Бид зусландаа буусан. Би морь унаж, хурга, ишиг хариулж бас ээждээ цагаан идээ авахад тусалдаг байв. Ах эгч нартайгаа хамт голын эрэгт очиж, усанд сэлж тоглосон.



Өнөр:

Бид гэр бүлээрээ аялах дуртай. Бид энэ зун улсынхаа нийслэл Улаанбаатар хотод очиж амарлаа. “Хүннү Молл”-д очиж, үлэг гүрвэлийн музей үзсэн нь хамгийн сонирхолтой байлаа.



Асуулт

- Хүүхдүүд хаана амарсан бэ?
- Хүүхдүүд юу хийж амарсан бэ?
- Чамд хамгийн их таалагдсан хэсэг аль нь вэ?
- Чи бусдад яаж амрахыг зөвлөх вэ? Яагаад?
- Эхээс түлхүүр үгсийг олж бүдүүвчээр илэрхийлж зураарай.
- Дараа нь тайлбарлан хэлнэ үү.
- Эхээс олж мэдсэн сургамжийг бичээрэй.



Б. Хүснэгтийн дагуу зуны амралтынхаа тухай яриарай.

Хэн?	Хэзээ?	Хаана?	Юу хийсэн?
Би	8 дугаар сард	Зост зусланд	амарсан



В. Тохирох үгийг олж нөхөж өгүүлбэр бүтээгээрэй.

Ашиглах үгс: хөдөө, зусланд, хотод, гар бөмбөг, шатар, домбор, өвөөдөө хурга хариулж, ээждээ дүүгээ асарч, найздаа ногоо услахад

..... амрав
 Би зуны амралтаараа тоглож сурав.
 туслав.



Г. Чамд тохиолдсон зуны дурсамжтай үйл явдлыг бүдүүвч ашиглан бичээрэй.

Хэн?	Хэн оролцсон бэ?	Хэзээ?	Хэзээ болсон бэ?
Юу?	Юу болсон бэ?	Хаана?	Хаана болсон бэ?
Яагаад?	Шалтгаан юу вэ?	Хэрхэн?	Үйл явдал хэрхэн өрнөсөн бэ?



Д. Доорх үгсийг бүлэглээрэй. Эр үг: Эм үг:

хурга	бөмбөг	дуу	унага	дасгал
хөдөө	хөгжим	Улаанбаатар	зуслан	сагс



Е. Дараах нөхцөлийг тохирох үгсэд залган бичээрэй. Дуу + -Ы

-ий -ИЙН -Ы -ЫН

Дасгал 2



А. Харилцан яриаг анхааралтай уншаад, дасгалыг ажиллаарай.



Сайн уу? Даваа! Чи хэзээ ирсэн бэ?

Сайн уу? Нараа! Би өчигдөр ирлээ.

Зуны амралтаа хаана өнгөрүүлсэн бэ?

Ямар гоё вэ?

Би "Зост" зусланд амарсан.

Тийм ээ, зуны амралт сайхан байлаа. Чи хаана амарсан бэ?

Би гэр бүлээрээ хөдөө эмээ өвөөгийндөө очиж амарсан.

Би хонь хариулахад тусалж, морь унаж сурсан.

Чи юу хийж амарсан бэ?

Өвөө эмээдээ туслах ч сайхан шүү!



Б. Хэрвээ чи Даваагийн оронд байсан бол өөр юуны тухай асуух байсан бэ? Яриарай.



В. Өгүүлбэрийг уншаад асуулт зохиож бичээрэй.

Асуулт	Хариулт
.....?	Даваа Зост зусланд амарсан.
.....?	Нараа морь унаж сурсан.
.....?	Нараагийн эгч цагаан идээ хийхэд тусалсан.



Г. Дараах үгсийг давтаж уншаарай. Уншихдаа зөв дуудаж, нүдлэн тогтоогоорой.

морь унах




хонь хариулах



хүүхдийн зуслан



зуслан



Д. Үгийн утгыг ойлгож аваарай. Цэгийн оронд нөхөж бичээрэй.

хана



гэрийн хана

Эгчий гэр ихэвчлэн 4 - 8
.....тай байдаг.

хаана?



газар орон, байршил
асуух үг

Танай гэр
байдаг вэ?

Дасгал 3



А. Эхийг уншаад асуултад хариулж бичээрэй.

Намар

Монгол орон жилийн дөрвөн улиралтай. Түүний нэг нь намар. Хүмүүс намрын улирлыг “алтан намар, баян намар” гэх мэтээр нэрлэдэг.

Намар өвс ногоо, мод шарлана. Жимс ногоо боловсордог. Хүмүүс өвлийн бэлтгэлээ хийнэ. Намар хичээл эхэлж, хүүхдүүд сургууль, цэцэрлэгтээ явдаг.

Асуулт



- Намрын улирлын онцлог юу вэ?
- Намрыг яагаад “алтан намар” гэж нэрлэдэг вэ?
- Хүмүүс намрын улиралд ямар ажил хийдэг вэ?



Б. Уншаад өгүүлбэр болгон бичээрэй.



болов. Хүүхдүүд



ирлээ. Хичээлийн шинэ

жилийн нээлт болж, сургуулийн захирал үг хэлэв.



хичээл

заав.



хичээлдээ идэвхтэй оролцов.



В. Үгсийг зөв байрлуулан өгүүлбэр бүтээж бичээрэй.

- намар шувууд Усны буцдаг
- зугаалах сайхан модоор Ой
- Мөнхөө хийлээ шөл байцайтай
- алт эрдэнэ Аавын сургаал ээжийн сургаал



Г. Дараах үгийг зөв уншаарай. Холбоо үг бүтээж бичээрэй.

ан	ань
доог	догь
чухал	цухал
чаг	цаг
сар	шар

нүдээ
..... тохуу
уур
..... дуугарах
..... өнгө

..... амьтан
..... эр
..... ажил
бугуйн
нар



Д. Өгүүлбэрээс хэн? юу? ямар? хэд? хэчнээн? хэзээ? хаана? яасан? гэсэн асуултад хариулагдах үгсийг олж бичээрэй.

Бид зун “Толбо нуур” амралтын газар луу явж, сайхан амарсан.

Хүмүүс намрын улирлыг “алтан намар, баян намар” гэх мэтээр нэрлэдэг.

Дасгал 4



А. Шүлгийг уран уншаарай.

Алийг нь ч гомдоохгүй

Хурганд явахдаа цэцэг тасдав! гэж
Өвөө минь захив.
Хунгийн дэгдээхэйг айлгаж орхив! гэж
Эмээ минь захив.
Хул даагаа цангааж орхив! гэж
Аав минь захив.



Айлын хүүхдүүдийг шоглов! гэж
Ээж минь захив.
Алаг сайхан цэцгийг
Амьтны нялх үрийг
Айлын хөөрхөн жаалыг
Алийг нь ч би гомдоохгүй.

Д. Базаррагчаа



Б. Үг нөхөж, өгүүлбэр бүтээж бичээрэй.

Хэн?

Юу гэж?

Миний

..... захидаг.

..... захидаг.

..... захидаг.



В. Үгсийг бүлэглэн бичээрэй.

Хэрэм, улаан лооль, газар, цас, анги, хүүхэд, алим, эмгэн, бороо, ширээ, бэлтрэг, гөлөг, морь, ном, самбар, чинжүү, жүрж, аав, чоно, дуучин, туулай, салхи,

Хүн	Ан амьтан	Сургууль	Жимс, ногоо	Байгаль, үзэгдэл
_____	_____	_____	_____	_____



Г. Үг бүтээгээрэй. Багана тус бүрээс утгаараа өөр үгийг олж бичээрэй.

жинман	→	манжин
гээшүү	→
бамсар	→
ээриш	→

гумаш	→
анхарада	→
галту	→
гээү	→




Д. Өгүүлбэрийг хуулж бичихдээ тохирох цэг тэмдгийг тавиарай.

Хээрийн ганган цэцгийг тасалсан уу

Хээрийн ганган цэцгийг бүү тасал

Хээрийн ганган цэцгийг тасалж болохгүй

Би хээрийн ганган цэцгийг таслахгүй





дасгалжуулагч



загвар өмсөгч



шүүгч



хөгжөөн дэмжигч



гар бөмбөг



сагсан бөмбөг



хөл бөмбөг



одон бөмбөг



биеийн тамирын талбай



тариалангийн талбай



ногооны талбай



хөл бөмбөгийн талбай



Эйфелийн цамхаг



үхрийн ферм



түрийвч



хожих



сэлэх



мөрөөдөх




түрүүлэх



ялах



А. Зургийг ажиглаад асуултад хариулж бичээрэй.



Болд юу хүсэж байна вэ?



Нараа юу мөрөөдөж байна вэ?



Сүхээ юу хүсэж байна вэ?



Сараа юу мөрөөдөж байна вэ?



Б. Хүүхдүүд юу худалдан авахыг хүсэж байна вэ? Яриарай.



В. Тохирох үгийг нөхөж бичээрэй.

Ашиглах үгс: хөл бөмбөгчин болохыг, тусч найзаараа, ягаан даашинз авахыг, хадаастай пүүз авахыг, Улаанбаатар хотод очихыг, гэр бүлээрээ

Би

..... хүсдэг.

..... мөрөөддөг.

..... бахархдаг.



Г. Дараах үгсэд тохирох олон тооны нөхцөлийг залгаж бичээрэй.

Эрдэмтэн, өвөө, ургамал, нохой, нарс, ард, үлэг гүрвэл, баян, эмч, мод, далай, сэтгүүлч, багш, морь, замаг, ажилчин

- ууд
- үүд
- чууд
- чуул
- чүүд
- нар
- с
- д

Дасгал 2



А. Харилцан яриаг уншаарай.

Билгүүн:

Миний аав ээж малчин. Би аав ээждээ туслах дуртай. Том болоод үхрийн фермтэй болж, **хүүхдүүдийг** эрүүл цагаан идээгээр хангахыг мөрөөддөг.

Ану:

Би хувцас загвар зохион бүтээгч болохыг мөрөөддөг. **Хүмүүс** миний бүтээсэн хувцсыг өмсөж яваасай гэж боддог.

Хулан:

Миний мөрөөдөл Парис хотод очих. Парис хотод Эйфелийн цамхаг байдаг. Би түүнийг үзэхийг хүсдэг.

Эрдэнэ:

Би хөл бөмбөгийн дасгалжуулагч болохыг хүсдэг. Ирээдүйд хөл бөмбөгийн багийг бэлтгэж тэмцээнд оруулахыг хүсдэг.

Тэмүүжин:

Би **найзуудтайгаа** хамт хөл бөмбөгийн улсын аварга шалгаруулах тэмцээн үзэхийг мөрөөддөг.



Б. Билгүүн, Ану, Хулан, Эрдэнэ, Тэмүүжин нарын дүрд тоглоорой. Тоглохдоо тохирох үг, өгүүлбэрийг нэмж оруулаад дэлгэрүүлээрэй.




Жишээлбэл:

Ану: Хүмүүс миний бүтээсэн хувцсыг өмсөж яваасай гэж боддог.



В. Зургийг ажиглаад нэрлэж бичээрэй.



Г. Эхээс тодруулсан үгийн утгыг ажиглаад ганц тоот болгож бичээрэй.

Жишээлбэл: хүүхдүүд-хүүхэд



Дасгал 3



А. Эхийг уншаад асуултад хариулаарай.

Намайг Болд гэдэг. Би сургуульд орсон цагаасаа л алдартай хөл бөмбөгчин болохыг мөрөөддөг байв. **Хөл бөмбөгийн оддын** зургийг цуглуулж ханандаа байрлуулдаг байв. Бас **тэмцээнүүдийг** тогтмол үздэг байлаа.



Би гуравдугаар ангидаа сургуулийн хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд орж, ямар ч бэлтгэлгүйн улмаас хожигдсон юм. Үүнээс хойш би хөл бөмбөгийн дугуйланд хичээллэх хэрэгтэйг ойлгосон. Мөн ангийнхаа **хөвгүүдийг** ч уриалав. Яагаад гэвэл хөл бөмбөг багийн спорт учраас багаараа тоглох хэрэгтэй гэдгийг ухаарсан.

Мөрөөдөж суухаас илүү мөрөөдлөө биелүүлэхийн тулд алхам алхмаар хичээх хэрэгтэй шүү, найзууд аа!

Асуулт

- Болд ямар хүн болохыг хүсдэг байсан бэ?
- Тэмцээнд ороод яагаад хожигдов?
- Болд мөрөөдлөө биелүүлэхийн тулд хэрхэн хичээсэн бэ?
- Ганцаараа тоглох, багаар тоглохын ялгаа юу бол? Та нар юу гэж бодож байна вэ?
- Чи мөрөөдлөө биелүүлэхийн тулд юу хийдэг вэ?



Б. Эхийг давтан уншаад тохирох гарчиг өгөөрэй.




В. Эхээс тодруулсан үгийг ганц тоот болгон бичээрэй.

Жишээлбэл: хөл бөмбөгийн одод - хөл бөмбөгийн од



Г. Дараах үгэнд тохирох нөхцөлийг залган бичээрэй.

тэмцээн, бөмбөг
дасгалжуулагч, тамирчин
загвар өмсөгч, баг
Болд



Д. Олон тооны нөхцөлийг залгаж болохгүй үг байсан уу? Яагаад?

Дасгал 4



А. Зургийг ажиглаад хэний зураг болохыг нь ярилцаарай.



Б. Танилцуулгыг уншаарай.

Криштиан Роналдо

Криштиан Роналдо бол Португалд 1985 онд төрсөн. Айлын дөрөв дэх хүүхэд юм. Хоёр настайгаасаа эхлэн хөл бөмбөг сонирхож, жижигхэн хашаан дотроо бөмбөг өшиглөжээ.

Тэр бөмбөг бэлгэнд авахыг юу юунаас илүү мөрөөддөг байжээ. Нэгэн өдөр аав нь мөрөөдлийг нь биелүүлж, түүнд бөмбөг бэлэглэв. Энэ нь тухайн үеийн Роналдогийн амьдралд хамгийн дурсамжтай мөч болжээ. Хүү үнэт бэлгээ одоо хүртэл нандигнан хадгалдаг аж.

Тэрээр найман настайгаасаа сурагчдын багт тоглож, амжилтын гараагаа эхлүүлсэн ба Манчестер Юнайтед багийн гол тоглогч болсон мөчөөс эхлэн алдаршсан юм.



В. Зураг болон түлхүүр үг ашиглан холбоо үг үүсгэн бичээрэй.



..... бөмбөг



..... талбай



Г. Тодруулсан үгийг тохирох үгээр сольж бичээрэй.

Ашиглах үгс: хожих, түрүүлэх, манлайлах, тэргүүлэх



Олон бөмбөг оруулсан багийг **ялсанд** тооцдог.

Дасгал 5

А. Харилцан яриаг уншаад асуултад хариулаарай.



Би мөрөөдөх дуртай. Чи юу мөрөөддөг вэ?

Чи хаана очиж, юу үзэхийг мөрөөддөг вэ?

Чи ямар сайхан зүйл бүтээхийг мөрөөддөг вэ?

Чи ямар мэргэжилтэй болохыг мөрөөддөг вэ?

Чи юу хийж бүтээхийг мөрөөддөг вэ?

Би ч бас мөрөөдөх дуртай. Надад олон мөрөөдөл бий.

Би Парист очиж Эйфелийн цамхаг үзэхийг мөрөөддөг.

Би хүмүүст тусалж “Сайн үйлсийн аян” санаачлан зохион байгуулахыг мөрөөддөг.

Би загвар зохион бүтээгч болохыг мөрөөддөг.

Би ирээдүйд алдартай загварын шоу бүтээхийг мөрөөддөг.



Асуулт

- Эйфелийн цамхаг аль хотод байдаг вэ?
- Сайн үйлсийн аянд ямар ямар ажил хийж болох вэ?
- Хувцас загвар зохион бүтээгч юу хийдэг вэ? Жагсаан бичээрэй.




Б. Та нар ирээдүйд хаана очиж, ямар мэргэжилтэй болж, юу хийж бүтээхийг мөрөөддөг вэ? Ярилцаарай.

В. Харилцан яриаг дуурайж дүрд тоглоорой.

Г. Дараах үгсэд тохирох нөхцөлийг залган бичээрэй.

хүсэл
мөрөөдөл
бахархал



би
чи
та

Д. “Миний мөрөөдөл” сэдвээр эх зохиож бичээрэй. Бичихдээ дараах бүдүүвчийг ашиглаарай.

Бичихийн өмнө

Бичих

Хянах

Засах

Нийтлэх

Бичих зүйлээ төлөвлөөрэй.

Анхны нооргоо бичээрэй.

Бичсэнээ улам сайн болгохоор дахин нягтлаарай.

Сайжруулснаа шалгаарай.

Бусадтай хуваалцаарай.

Дасгал 6

А. Харилцан яриаг төлөөлөн уншаарай.

Билгүүн зам дээрээс мөнгө олоод маш их баярлав.



Ямар гоё вэ! Ямар их мөнгө вэ? Дэлгүүр яваад зайрмаг авъя.

Тэр эмээг гүйцэж очоод, мөнгийг нь өглөө.

Миний эмээ шиг л хүн байна. Би тэр хүнд мөнгийг нь эргүүлж өгөх ёстой.

Эмээ дэлгүүр явж байв.

Дэлгүүрээс сүү, талх, эмийн сангаас эм авъя.



Эмээ мөнгөө гээж, уйлах шахав.

Би ямар азгүй юм бэ! Мөнгөө хаячихжээ. Одоо яах билээ?

Эмээ маш их баярлав.

Ямар сайхан сэтгэлтэй хүү вэ! Маш их баярлалаа. Ийм сайн хүүгээр бахархаж байна.

Б. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж эх зохион бичээрэй.

Билгүүн гэр лүүгээ явж байв. Тэр олоод баярлав.авна гэж бодов. Дараа нь эмээг олж харав. Эмээ зогсоод хайж байв. Билгүүн гүйцэж очоод өгөв. Эмээ маш их, гэж хэлэв.

В. Зураг дээрх үйл явдлыг яриарай.



Г. Үгийн утгыг ойлгож, цэгийн оронд нөхөж бичээрэй.

эд



эд бараа, эд хөрөнгө

Эдэн нь мөнх, нь хэврэг байл.

ид



юм идэх

Эрүү шүдтэй байя гэвэл ааруул сайн

Дасгал 7




А. Танилцуулгыг уншаад асуултад хариулж бичээрэй.

Миний унших дуртай ном

Ном уншвал толгой сэргэж, ой тогтоолт сайн болдог. Уншсан номын тоогоор шинэ газар очиж, шинэ хүнтэй танилцдаг.

Ном уншсанаар алдаагүй бичиж, зөв хурдан уншдаг болно. Ном хүн бүрийн багш, дотны найз юм. Ном бол бидэнд олон сургамж өгч чадна.

Миний уншсан хамгийн сонирхолтой ном “Алтан загасны үлгэр” юм. Энэ номд хүсэл биелүүлэгч Алтан загасны тухай өгүүлдэг. Би энэ номыг уншаад өөрт байгаа зүйлдээ сэтгэл хангалуун байх хэрэгтэй гэдгийг ойлгож авлаа.



Асуулт

- Ном уншихын ач холбогдол юу вэ?
- Чи хамгийн анх ямар ном уншсан бэ?
- Тэр номонд юуны тухай өгүүлсэн байдаг вэ?



Б. Номын тэмдэглэл хөтлөхөд юуг анхаарах вэ? Ярилцаарай.

НОМЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛЖ СУРЦГААЯ!

Номын тэмдэглэл хөтлөх нь ой тогтоолт, анхаарал төвлөрөл, бичих чадварыг сайжруулах давуу талтай. } Уншсан номынхоо талаар дүгнэж, тэмдэглэл бичихдээ номын утга санааг бүхэлд нь ойлгоход чиглүүлэн уншаарай.



1. ТАНИЛЦАХ ХЭСЭГ

- Зохиолын нэр, номын зураг, зохиолчийн нэр, намтар, уран бүтээлтэй танилцана.

2. БҮТЭЭЛЧ УНШЛАГА

Үйл явдлын зураглал

- Харж дуурайлган зурна.
- Сэтгэж зохиомжлон зурна.

Дүр

- Дүрүүдийн гадаад ба дотоод шинж чанар, бусад дүрүүдтэй харьцуулж, таамаглан бичнэ.

Үг, өгүүлбэрийн утга

- Утгыг нь мэдэхгүй үг, хэлц үгийг тайлбарлаж, таалагдсан үг, өгүүлбэрийг тэмдэглэнэ.

3. ДҮГНЭЛТ ХЭСЭГ

Мэдрэмж, сэтгэгдэл

- Номыг уншиж байх явцад төрсөн бодол, мэдрэмжээ илэрхийлнэ.

Үзэл бодол

- Номын тухай өөрийн бодлоо илэрхийлнэ.

Ухаарал, сургамж

- Юуг ойлгож ухаарснаа бичнэ.
- Зөвлөмж, заавар бичнэ.



В. Дараах зургийг ашиглан өгүүлбэрүүдийг үйл явдлын зөв дараалалд оруулж бичээрэй.




Ашиглах өгүүлбэрүүд:

- Өвгөн загас барьж, далайн хөвөөг сахина.
- Эмгэн утас ээрч, гэрийн мухар сахина.
- Гурав дахь удаа алтан загас баригдав.
- Эвдэрхий муу тэвшээ шинэ тэвшээр солив.
- Гэр байсан газарт нь том цагаан байшин харагдаж гэнэ.
- Ноос ээрдэг эмгэн нь ноён болжээ.
- Хатан хаан болоод хамаг олныг захирч гэнэ.
- Өвгөнийг хол газар зайлуулж явуулжээ.
- Газар гэрт эмгэн нь ээрүүлээ бариад дэргэд нь эвдэрхий тэвш нь байжээ.



Г. Доорх загварыг ашиглан “Алтан загасны үлгэр” номын тэмдэглэл бичээрэй.



Д. Номын тэмдэглэлийн жишээг уншаад ярилцаарай.

НУУЦ *Узүрлэг*

Зохиолчийн нэр: Франсис Лоджсон Барнет

Номын төрөл: Нууцдгийн Уран Зохиол

Төвлөсөн он: 1911 Төвлөлийн газар: Мурман

Номын тухай: Мэри Леннокс өвчтэй үеэл ахтайгаа Йоркшир дахь том байшинд нь хашт амьдрахаар ирж, нууц цуцэрлэгийн түлхүүр олон авга ахынхаа хүүртэй цуг засаж, хүүр эргэн алхаж сурладаг.

Таалагдсан дүр: Дикон, Мартагийн дүү
Мэригийн найз

Таалагдсан хэсэг: Дикон, Мэри, Колин цуцэрлэгийн засан, цагай тэнд өнгөрүүдэг хэсгүүд.

Таниаардан баатруудад хэрхэн нөлөөлсөн бэ? Мэри эрх, муухай аацтай, Колин зожил бүдүүрэг байсан.

Номоос сийлгөсөн зүйл: Сайхан сэтгэлээр амьдрал хүүий сэтгэлийг цэвэрлэж болно.

Тэрбээ гал дунд
тохиолдсон зүйл чамд ч
бас тохиолдож байсан
бол тэр талаараа
бүтээгдэй ♥

Дасгал 8



А. Эхийг уншаад асуултад хариулаарай.

Бахархал гэж юу вэ?

Хүний сайн сайхан зан чанар, зөв үйлдэл, давуу талыг хүндэтгэхийг бахархал гэнэ. Бахархал гэхээр л хэтэрхий их, том байх хэрэггүй. Маш энгийн жижиг зүйлээр ч бусад хүмүүсээс өөр байж болдог. Хүн өөрийн гэр бүл, найз нөхдөө танин мэдэж, түүгээр бахархах ёстой. Бахархмаар хүмүүсээс үлгэр дуурайл авах нь чухал юм.

Асуулт

Юуны тухай уншсан бэ?

- Эхлэл хэсэгт
- Гол хэсэгт
- Төгсгөл хэсэгт

Чамд ямар санагдсан бэ?

- Надад санагдсан.
- Намайг эргэцүүлэхэд хүргэсэн.
- Надад ойлгуулсан.



Б. “Миний бахархал” сэдвээр эх зохион бичээрэй. Бичсэнээ дараах хяналтын хуудсаар хянаарай.

Хянах хуудас

- Том үсгээр бичсэн эсэх
- Догол мөр болон үг хоорондын зайг зөв авсан эсэх
- Цэг тэмдгийг зөв хэрэглэсэн эсэх
- Зөв бичих дүрмийн алдаагүй эсэх



В. Бахархмаар зан чанарыг ялган бичээрэй.

ажилсаг

залхуу

шударга

атаархуу

тусч

өрөвч

ховч

энэрэнгүй

цайлган



Г. Үгийн утгыг ойлгож аваарай. Цэгийн оронд нөхөж бичээрэй.

байцаа



учрыг олохоор олон дахин асуух, шалгаах

Дүрэм зөрчвөл цагдаа намайг

.....

байцай



хүнсний ногоо

..... бол хүнсний ногооны нэг юм.

ГЭР БҮЛ

Зуралт толь



ногоо услах



машин угаах



тоос соруулах



ор хураах



ширээ засах



муур хооллох



тоос арчих



хувцас угаах



хувцас хатаах



нохой салхилуулах



тоглоом хураах



хоол хийх



цонх угаах



хувцас эвхэх



түлээ зөөх



мал услах



төл нэмнэх



аргал түүх



өвс хамах



төл угжих



А. Харилцан яриаг уншаад даалгаврыг ажиллаарай.



Манай гэр бүлийн гишүүн бүр өөрийн хийдэг ажилтай.

Бид хийж чаддаг ажлаа бусдаар шаардуулахгүй хийдэг.

Ээж амттай хоол хийдэг.

Аав мал хариулдаг.

Аялгуу эгч маань хувцас угааж, индүүддэг.

Тулгаа ах нүүрс түлээ хагалж, ус зөөдөг.

Би өдөр бүр гэрээ цэвэрлэж, хогоо хаядаг.



Манайхан ч бас өөр өөрийн үүрэг хүлээдэг.

Аав ээж хоёр маань өглөө эрт ажилдаа явдаг.

Эмээ минь амттай сайхан хоол хийдэг.

Харин өвөө минь дүүг цэцэрлэгт хүргэдэг. Намайг даалгавраа хийхэд тусалдаг.

Харин дүү маань бидэнд тусалдаг.

Би өдөр бүр ээждээ хоол хийхэд нь тусалж, аяга таваг угаадаг.



Б. Эгшиглэнгийн гэрийнхнээс хэн юу хийдэг вэ? Өгүүлбэрийг гүйцээж бичээрэй.

Эгч хувцас,
 Аав малаа
 Ах түлээ
 ус Ээж амттай
 хоол Эгшиглэн хоол
 хийхэд, аяга тавгаа



В. Батын гэрийнхнээс хэн юу хийдэг вэ? Өгүүлбэрийг гүйцээж бичээрэй.

Ээж явдаг. Эмээ
 хийдэг. Аав
 явдаг. Өвөө
 хүргэдэг. Өвөө намайг

 тусалдаг. Бат цэвэрлэж,
 хаядаг. Ах түлээ



Г. Найзаасаа асууж, ярилцаарай.

- Найзынхаа гэр бүлд “хоол хийх, дэлгүүр лүү явах, аяга таваг угаах, гэр эд хогшил засварлах, хувцас хунар угаах, гэр цэвэрлэх” зэрэг ажлуудыг хэн хэн хийдэг болохыг асуугаарай.
- Авсан мэдээлэлдээ тулгуурлан гэр бүлийнхээ гишүүдийн хэн хэн нь гэрт ямар ажлыг хийдэг талаар бичээд, ярилцаарай.



Д. Зүйр цэцэн үгсийг уран уншаарай. Утгыг тайлбарлан яриарай.



Гар хөдөлбөл
Ам хөдөлнө



Дэм дэмэндээ
Дээс эрчиндээ



Ажил сурвал
Амьдралд тустай



Дасгал 2

А. Шүлгийг хуулж бичээрэй. Бичихдээ өргөлтөт эгшгийн дээр ✓ тэмдэглээрэй.

Б. Шүлгийн өргөлт, зогсолтыг зохицуулан уншаарай.



Ах, эгч, дүү бид

Том ах түлээ хагална
Бага ах түүнийг хураана
Өндөр эгч цай чанана
Өөрөө би гэрээ цэвэрлэнэ
Аравтай дүү аяга угаана
Жижиг дүү цэцэг усална
Унд хоол бэлэн зэлэн
Угааж арчаад бүгд цэвэрхэн
Аав ээж ажлаас ирээд
Алжаал тайлж аятай амарна
Хүүхдийн тус их ээ гэж
Хөрш айлынхан биднийг магтана



Ц.Эрдэнэбат

В. Ялгах эгшгийн доогуур зураарай.

Г. Яагаад ялгах эгшиг гэсэн бэ? Юуг юунаас ялгаж байгааг тайлбарлан бичээрэй.

Д. Доорх зургуудыг ашиглан шүлэг зохиож бичнэ үү.



Дасгал 3



А. Эхийг уншаад доорх асуултад хариулж бичээрэй.

Том болсон нь

Хулан охин хурдан том болохыг маш их хүсдэг байв. Яаж том болохыг мэдэхгүй л байсан тул ээжийнхээ өсгийтэй гутлыг нь, эмээгийнхээ цамцыг нь өмслөө. Эгч шигээ үсээ янзалж, бугуйн цагийг нь зүүлээ. Гэвч том болсонгүй. Бүгд түүнийг хараад инээж байв.



Нэг өдөр Хулан гэрээ цэвэрлэхээр шийдэж, цэмбийтэл цэвэрлэв. Ээж нь гайхаж: - Хулан минь, том болсон байна даа гэв. Өдрийн хоолны дараа Хулан бүх аяга тавгаа угааж цэвэрлэв. Тэдний гэр бүлийнхэн Хуланг хараад гайхаж байлаа. Бүгдээрээ:

- Бид Хулангийнхаа ямар том болсныг анзааралгүй явсан байна даа. Гэрээ цэвэрлээд, бас аяга таваг угааж чаддаг болсон байна гэв.


Одоо бүгд “жижигхэн” Хуланг “том” Хулан гэж дууддаг болжээ.

Асуулт

- Яагаад Хуланг хараад бүгд инээсэн бэ?
- Ээж нь яагаад гайхав?
- Жижиг Хулан яаж том Хулан болов?
- Та нар том болохын тулд юу хийх байсан бэ?



Б. Холбоо үг үүсгэн дэвтэртээ бичээрэй.




В. Холбоо үгээ оролцуулан өгүүлбэр зохиож бичээрэй.



Г. Эхээс хамаатуулах нөхцөлтэй үгийг түүж бичээрэй.



Д. Эхэд тохирох зүйр цэцэн үг бичээрэй.



Дасгал 4



А. Эхийг уншаад даалгаврыг ажиллаарай.

Гэр бүлийн аялал



Намайг Тэгшээ гэдэг. Энэ манай гэрийнхэн. Энэ зуны амралтаар бид Алтай Таван Богд руу аялсан юм.

Аялал маань тун хөгжилтэй байлаа. Гэрээсээ гараад бид машиндаа шатахуун хийж аваад хөдөллөө. Замын турш аав жолоо барьж, ээж аавыг уйдаахгүйн тулд сонирхолтой түүх ярив. Харин би газрын зураг харж, зам зааж өгөв. Эгч минь хөгжим сонсож, зураг авч явлаа. Харин ах маань бидэнд ус дөхүүлж, самар жимс ойртуулах ажил хийв. Дүүгийн минь хийсэн ажил их сонирхолтой. Тэр бол “унтах”.


Хүрэх газраа ирээд бид хурдан гэгч нь майхнаа барилаа. Ах усанд явж, аав гал түлэн, ээж эгч хоёр аагтай шаргал цайгаа чанаж, амттай хоолоо хийж идлээ. Би бяцхан ширээ засав. Дүүгийн минь ажил харин “идэх” байлаа. Эвий бяцхан дүү минь ирэх жил тусад орно доо.

Асуулт

- Тэгшээгийн гэр бүлийнхэн хаашаа аялсан бэ?
- Аялахдаа юугаар явсан бэ?
- Тэгшээ ямар үүрэгтэй явав?
- Дүүгийн ажлыг яагаад сонирхолтой гэсэн бэ?
- “Тусад орох” гэсэн үгийн утгыг дэлгэрүүлэн тайлбарлаарай.





Б. Доорх загварын дагуу үйл явдлыг яриарай.



В. Эхийн үйл явдал хаана, хэзээ өрнөж байна вэ? Бичээрэй.



Г. Онъсогыг таагаарай.



Д. Хамгийн сайхан дурсамжтай аяллынхаа тухайгаа хүүрнэн бичээрэй.



А. Шүлгийг уншаад асуултад хариулж бичээрэй.

Хамгийн залхуу охин хаана амьдардаг вэ?

Энэ асуултад хариулах юм бол
Ээж аавынх нь нэр хайран
Яаж харин залхуурдгийг нь
Яг үнэнээр нь бичье



Хагалсан түлээ оруулаач гэж
Хайртай эмээ нь хэллээ
Эмээ минь, эмээ минь байзнаарай
Эвий охиноо хайрлаарай
Хамаагүй их зөөчихвөл
Хайран түлээ дуусчихна
Модны өргөс гарт минь орчихвол
Мондийн тэднийг та л түүнэ
Охин нь эмээдээ ингэж хэллээ
Одоохон одоохон гэж хойшлууллаа
Ээж нь ажлаасаа ирлээ
Эвийлж охиноо үнсээд
Шалаар хөглөрсөн тоглоомоо
Шалавхан хураахыг хүслээ
Хүүхэлдэй бамбарууш хоёр маань
Хөлөө жийгээд унтаж байна
Хун галуу хамтдаа
Хувинтай усанд зүүрмэглэж байна
Нойрмог эднийг сэрээгээд яах вэ?
Нойроо ханатал унтаг ээж ээ
Охин нь ээждээ ингэж хэллээ
Одоохон одоохон гэж бас л залхуурлаа.

О. Сундуй

Асуулт

1. Юуны тухай уншсан бэ?

- Эхлэл хэсэгт
- Гол хэсэгт
- Төгсгөл хэсэгт



Асуулт

2. Ямар үйл явдал болсон бэ?

- Эмээ юу гэж хэлсэн бэ?
- Охин юу гэж хариулсан бэ?
- Ээж юу гэж хэлсэн бэ?
- Охин юу гэж хариулсан бэ?
- Охин юу хийсэн бэ?
- Үйл явдал хаана болсон бэ?
- Хамгийн чухал үйл явдал юу байв?
- Ямар асуудал тулгарав?



Асуулт

3. Чамд ямар санагдсан бэ?

- Надад санагдсан.
- Намайг эргэцүүлэхэд хүргэсэн.
- Надад ойлгуулсан.
- Надад өмнө нь ийм зүйл тохиолдож байсан билүү?
- Энэхүү явдлаас дүгнэхэд.....
- Одоо л-г ойлгож авлаа.



Б. Шүлгийг цээжлээд уран уншаарай.



В. Утгаараа ойролцоо үгсийг түүж бичээрэй.

Ашиглах үгс: гунигтай, баяртай, онцгүй, жаргалтай, гонсгор, уцаартай, өөдрөг, гутарсан

Сэтгэл хангалуун:

Сэтгэл хангалуун били:



Г. Зүйр цэцэн үгсийн утгыг тайлбарлаж бичээрэй.

Зовлонд бүү сөхөр
Жаргалд бүү ташуур

Чамлахаар
Чанга атга.

Өвстэй газар
мал тогтохгүй
Жаргалтай газар
хүн тогтохгүй



Д. “Ход ход инээх” гэсэн үгийн утгыг тайлбарлаарай. Инээдийг өөрөөр хэрхэн дүрсэлж болох вэ? 5 -аас доошгүй жишээ бичээрэй.



..... ИНЭЭХ

..... ИНЭЭХ

..... ИНЭЭХ

..... ИНЭЭХ

..... ИНЭЭХ



Е. Өгүүлбэрийг асуух, анхааруулах өгүүлбэр болгон бичээрэй.



Бид өөртөө байгаа зүйлийнхээ үнэ цэнг ойлгох нь чухал.



Ё. Цэгийн оронд нөхөж бичээд үг, өгүүлбэрийг зөв дуудан уншаарай.

үнэ

эд юмсыг мөнгөөр
үнэлсэн үнэ

*Энэ ном хорин таван мянган
төгрөгийн*

үнээ

үхрийн эм нь

*Балдний сүү
уух дуртай.*

Дасгал 7



А. Эхийг уншаад асуултад хариулаарай.

... Манайх хоёр үнээ, гурван бяруутай. Таван жилийн өмнө сургуульд ороогүй байхдаа би үхрээ хариулдаг байсан. Би ч “ажилтай” малчин хүү байжээ.

Үхрээ яаж хариулдаг байсныг минь та нар сонирхож байна уу? Би өглөө үхрээ туугаад Сэлбийг уруудуулан жаахан явж байгаад гэрлийн хорооны баруун зүлэгт хүрнэ. Тэнд гурван бяруугаа урт олсоор утасны модноос аргамжиж орхино. Тэгээд хоёр үнээгээ “Битгий салаад явчхаарай” гэж зандчаад сүүлний нь үзүүрийг зангидаж холбоод Дунд гол гаргаад туучихдаг байсан юм ...

Ш. Гаадамба “Багын явдал”

Асуулт



- Хүү өөрийнхөө талаар юу гэж хэлсэн бэ?
- Үйл явдал хэзээ, хаана болсон бэ?
- Бяруугаа яаж хариулдаг байв?
- Үнээгээ яаж хариулдаг байв?
- Сүүлийг нь ямар зорилгоор зангидсан бол?
- Хүү гэрийн ажилдаа тус нэмэр болж чадсан болов уу?



Б. Доорх загварын дагуу үйл явдлыг бичээрэй.



В. Хөдөөний малчин хүүхдүүд гэрийнхэндээ хэрхэн тусалдаг бол? Зургийг ашиглан яриарай.



Г. Онъсогыг таагаарай. Яагаад ингэж дүрсэлснийг бичээрэй.

Урдаа сэрээтэй
Дундаа хөхүүртэй
Ардаа ташууртай



Харахад хүйтэн
Барихад бүлээн

Дасгал 8



А. Танилцуулгыг уншаад асуултад хариулаарай.

ЭНЭ БОЛ МИНИЙ ГЭР БҮЛ



Манай гэр бүлийн эрхэмлэдэг зүйл гэвэл бие биедээ болон бусдад туслахыг хичээдэг. “Үнэнч шударга, хөдөлмөрч явахад хүн сайхан амьдарна даа” гэсэн өвөөгийн сургаалаар л явдаг даа. Би гэр бүлээрээ маш их бахархдаг.

Асуулт

- Гэр бүлийн гишүүдийн хэн хэн, ямар сайн сайхан зан чанартай вэ?
- Өвөө юу гэж сургасан бэ?
- Гэр бүлийн эрхэмлэдэг зүйл юу вэ?



Б. Өөрийн гэр бүлийн гишүүдийн сайн сайхан чанарыг загварын дагуу бичээрэй.

Жишээлбэл: Би бахархдаг. Учир нь



В. Бичсэн 2 өгүүлбэрээ нэг өгүүлбэрт багтаан “учраас” холбох үгийг ашиглан илэрхийлээрэй.



төгөлдөр хуур



бүрээ



морин хуур



хийл



даам



номын сан



зуслан



аварга



аялгуу



дуулах



бүжиглэх



зурах



амрах



нисэх



буух



үсрэх



мал хариулах



урсах



цулбуур



бургих



А. Харилцан яриаг анхааралтай уншаад, асуултад хариулж бичээрэй.



Анужин чи ямар дугуйланд явдаг бэ?

Би шатрын бас бүжгийн дугуйланд явдаг.

Өө, тийм үү би төгөлдөр хуурын дугуйланд явдаг. Хоёр жил болж байна.

Танай сургуульд ямар ямар дугуйлан хичээллэдэг вэ?



Гар бөмбөг, сагсан бөмбөг, теннис, дуу, бүжиг, даам, морин хуур, домбор, зургийн дугуйлан хичээллэдэг.

Олон дугуйлан байдаг юм байна. Гоё юм аа.

Хичээлд орох цаг болчихлоо. Баяртай.

Дараа уулзъя. Баяртай.

Асуулт

- Анужин ямар дугуйланд явдаг вэ?
- Ариунаа ямар дугуйланд явдаг вэ?
- Ариунаагийн сургуульд ямар ямар дугуйлан хичээллэдэг вэ?
- Чи ямар дугуйланд явахыг хүсдэг вэ?



Б. Харилцан ярианаас урлаг, спортын дугуйланг ялгаж бичээрэй.

Урлагийн дугуйлан

Спортын дугуйлан



В. Өөрийн сонирхдог дугуйлангийн тухай яриарай.



Г. Хүснэгтийг бөглөж бичээрэй.

Богино эгшиг нь гээгдсэн үг

Богино эгшиг нь гээгдээгүй үг



Д. Дараах үгсийг ашиглан 1-5 өгүүлбэр зохиож бичээрэй.

Ашиглах үгс: дугуйлан, дуу, даам, сургууль, өдөр бүр, хичээллэдэг, багш нар



Е. Үгсийг харьцуулж, зөв дуудан уншаад, өгүүлбэр болгож бичээрэй.

ДУУ дуулах

дуу чимээ

ой ухаан

ой мод

хүний гар

ангиас гар

саяхан ирлээ

сайхан байгаль

Дасгал 2



А. Эхийг уншаад, ойлгосноо яриарай.

Шатар

Шатар хүний ой ухааныг хөгжүүлдэг тоглоом. Анх Энэтхэгт үүссэн түүхтэй. Чөлөөт цагаараа шатар даам тоглох нь хүүхэд бидний оюуны хөгжилд тустай.

Саяхан Польшийн нийслэл Варшав хотод болсон шатрын түргэн тоглолтын дэлхийн аварга шалгаруулах тэмцээний үеэр дэлхийн аварга Норвегийн Магнус Карлсен 17 настай Узбек хүүд хожигджээ.



Асуулт

- Шатар юуг хөгжүүлдэг вэ?
- Шатар анх хаана үүссэн бэ?
- Чөлөөт цагаа зөв өнгөрүүлэхийн тулд яах ёстой вэ?
- Варшав хотод ямар тэмцээн болсон бэ?
- Тэмцээнд хэн түрүүлсэн бэ?
- Магнус Карлсен хэнд хожигдсон бэ?
- Ямар үгийг том үсгээр бичдэг вэ? Эхээс түүж бичээрэй.



Б. Цэгийн оронд тохирох үгийг оролцуулж яриарай.

Шатар үүссэн. Шатар даам тоглох нь тустай. Польшийн Варшав хот юм. Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд.....түрүүлжээ.



В. Дугуйлангийн мэдээллийг нөхөж бичээрэй.

ДУГУЙЛАНГИЙН МЭДЭЭЛЭЛ

Дугуйлангийн нэр

Өдрүүд

Хаана

Шатрын дугуйлан

Даваа-Баасан

201 тоотод

.....

.....

.....



Г. Дугуйлангийн хуваарийг бичээрэй.

Даваа	Мягмар	Лхагва
Пүрэв	Баасан	Бямба

Дасгал 3



А. Шүлгийг уншаад, асуултад хариулаарай.

Олуулаа

Хүүхдүүд бид нар сургууль дээрээ
Хөгжилтэйхөн байдаг даа
Олуулаа бид дуулдаг даа
Олуулаа бид **бүжиглэдэг**
Олуулаа, олуулаа, олуулаа



Багачууд бид нар сургууль дээрээ
Баясалтайхан байдаг даа
Олуулаа бид **уншдаг** даа
Олуулаа бид **хөгжимддөг**
Олуулаа, олуулаа, олуулаа

Асуулт

- Шүлэгт юуны өгүүлж байна вэ?
- Сургуулийн тухай ямар дуу, шүлэг мэдэх вэ?
- Хүүхдүүд сургуульдаа юу хийдэг вэ?
- Тодруулсан үгс нь юуг заасан байна вэ?



Шүлгийг уншихдаа:

- Үгээ тогтооно.
- Зөв уншина.
- Уран уншина.
- Тод уншина.
- Дууны өнгийг тохируулан уншина.



Б. Өөрийнхөө мэдэх нэг шүлгийг дэвтэртээ бичээрэй.



В. Зургийг ажиглаад эх зохиож бичээрэй.



Г. Доорх зурагт хэн юу хийж байгааг яриарай.



Д. Үгсийг харьцуулж, зөв дуудан уншаарай.

морин хуур

түүхийн анги

хонины ноос

жимс түүх



Е. Өгүүлбэр зохион ярилцаарай.

Цэцэг + (-ийн) найз

Гэрэл + (-ийн) дүү

Дархан + (-аас) ирэх

цэцэг (-ийн) сав

гэрэл + (ийн) шил

дархан + (-ы) багаж

шатар + (-ын) тэмцээн

зураг + (ийн) хичээл

бүжиг + (ийн) багш

Дасгал 4



А. Эхийг уншаад, асуултад хариулаарай.

Монгол хэлний хичээл орж байлаа. Багш надаас “хэцүү” асуулт асуув. Би хичээсэн боловч хариулж чадсангүй. Багш манай ангийнхнаас “Тэгшээд туслах хүүхэд байна уу?” гэж асуухад Болд тусалж би ч хүнд байдлаас амархан гарлаа. Үүнээс хойш Болд бид хоёр сайн найзууд болсон юм.

Бид хичээлтэй үедээ бие биедээ тусалж, чөлөөт цагаа хамт өнгөрүүлдэг. Тэр маш их авьяастай. Дуулна, хөгжим тоглоно бас гар бөмбөг, сагсан бөмбөгөөр хичээллэдэг.

Миний найзын надад хамгийн таалагддаг зан чанар бол тусч, энэрэнгүй, хөдөлмөрч зан юм. Бид хөгшин болтлоо найзална гэж би боддог.

Асуулт

- Тэгшээ Болдтой хэрхэн найзалсан бэ?
- Болд ямар авьяастай вэ?
- Болд ямар зан чанартай вэ?
- Чиний найзыг хэн гэдэг вэ?
- Чиний найз ямар авьяастай вэ?
- Чиний найз ямар зан чанартай вэ?
- • Чи найзтайгаа анх яаж танилцаж, найз болж байсан бэ?




Б. Асуултыг нөхөж бичээрэй.

Асуулт	Хариулт
..... ?	Болд Тэгшээд тусалсан өдрөөс эхлэн тэд дотно найзууд болсон.
..... ?	Болд дуулна, хөгжим тоглоно бас гар бөмбөг, сагсан бөмбөгөөр хичээллэдэг.
..... ?	Тэгшээд Болдын тусч, энэрэнгүй зан чанар таалагддаг.



В. Дараах бүдүүвчийг ашиглан холбоо үг, өгүүлбэр зохион бичээрэй.





Г. “Танилцуулга бичих таван алхам”-ыг уншаад найзынхаа танилцуулгыг бичээрэй.

Алхам 1.

- Найзынхаа нэр, дүр төрх, угсаа гарлыг бичнэ.
- Нөхөрлөлийн тухай өөрийн бодлоо бичнэ.

Алхам 4.

- Түүний хамгийн дуртай болон дургүй зүйлийг бичнэ.



Танилцуулга

Үндсэн хэсэг

Дүгнэлт

Алхам 2.

- Найзтайгаа хэрхэн танилцсанаа бичнэ.

Алхам 3.

- Түүний хийж байсан сайн үйл болон түүний зан чанарыг тодорхойлж бичнэ.

Алхам 5.

- Тэр яагаад чиний найз болсон тухай бичнэ.
- Ирээдүйгээ найзтайгаа хэрхэн төсөөлж буйгаа бичнэ.



Д. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй.

Нөхөх үг: дайсан, танигдана, эзэн, нөхөр, нөхрөө, нөхөр, зовох, өөрийгөө



Инээсэн бүхэн

..... биш

Уурласан бүхэн

..... биш



..... харж

.....зас



..... цагт

Нөхрийн чанар

.....



Сайн хүнд олон

Сайн моринд олон



Дасгал 5



А. Зурагт гарчиг өгөөд, асуултад хариулж бичээрэй.




Асуулт

- Ямар улирал вэ?
- Хоёр найз хаана тоглож байсан бэ?
- Тэд хэнийг харсан бэ?
- Охиныг хэн аварсан бэ?



Б. Дараах үгсийг харьцуулан уншаарай. Утгын ялгааг гаргаж, өгүүлбэр зохиож бичээрэй.





В. Үг- холбоо үг- өгүүлбэр бүтээгээрэй.

	холбоо үг	3 үгтэй өгүүлбэр	4 үгтэй өгүүлбэр
нөхөр	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>



Г. Зүйр үгийн цэгийн оронд тохирох үгийг бичээд цээжлээрэй.

 Сайнтай нөхөрлөвөл Муутай нөхөрлөвөл	 Зовох цагт танигдана
---	--

Дасгал 6



А. Эхийг уншаад, асуултад хариулж бичээрэй.

Найз

Намайг Эгшиглэн гэдэг. Миний найзыг Номин гэдэг. Бид хоёр нэгдүгээр ангиасаа эхлэн нэг ширээнд сууж найзалсан. Одоо дөрөвдүгээр анги боллоо. Тэр их гоё дуулдаг. Бас зураг зурдаг. Бид зуны амралтаараа хамт “Зост” зусланд амарсан. Би найздаа монголын нэрт зохиолч Ч.Чимэдийн “Би монгол хүн” шүлгийн эхний мөрийг чанга дуугаар уншиж өглөө.



... Аргалын утаа боргилсон
Малчны гэрт төрсөн би
Атар хээр нутгаа
Өлгий минь гэж боддог..


Харин Номин надад “Бага ангийн багшдаа баярлалаа” дууг дуулж өгсөнд би их баярласан. Бид хоёр хичээлээ ч хамт давтдаг. Хамт тоглодог. Найздаа үнэнч тусархаг байгаарай.

Асуулт

- Эгшиглэнгийн найзыг хэн гэдэг вэ?
- Тэд хэддүгээр ангид сурдаг вэ?
- Эгшиглэн, Номин хоёр хамт байхдаа юу хийдэг вэ?
- Тэд зуны амралтаараа хаана амарсан бэ?
- Эгшиглэн найздаа хэний ямар нэртэй шүлгийн хэсгийг уншиж өгсөн бэ?
- “Бага ангийн багшдаа баярлалаа” дууг мэдэх үү? Багшийнхаа тусламжтайгаар дэвтэртээ бичээрэй.



Б. Дараах үгсээр холбоо үг бүтээж бичээрэй.



В. Холбоо үгсээр өгүүлбэр зохиож бичээрэй.

Дасгал 7



А. Харилцан яриаг уншаарай.



Аймгийн нийтийн номын сан хаана байдаг вэ?

Аймгийн нийтийн номын сан хөгжимт драмын театрын хажууд хоёр давхар байшинд байдаг.



Чи нийтийн номын санд очиж үзсэн үү?

Би 7 хоног бүрийн пүрэв гарагт тогтмол очдог.

Тэнд уншлагын танхим бий юу?

Уншлагын хоёр том танхимтай 1дүгээр танхим нь том хүмүүсийн, 2 дугаар нь хүүхдийн уншлагын танхим.

Найз аа тэгвэл хоёулаа нийтийн номын сангаар орох уу?

Тэгье. Хамт оръё.

Сайн байна уу? Эгч ээ.

Сайн. Сайн байцгаана уу?



Бид хоёр уншлагын танхимд сууж ном унших гэсэн юм.

Та хоёр ямар ном унших вэ?

Би адал явдалтай, үлгэрийн ном унших дуртай. Монгол ардын үлгэрийн номууд байгаа юу?

Байгаа. Чи ямар ном унших вэ?

Би хошин шог, инээдмийн ном уншмаар байна.

Асуулт

- Туяа хэзээ номын санд очдог вэ?
- Номын сан хэдэн уншлагын танхимтай вэ?
- Туяа ямар ном унших дуртай вэ?
- Туул ямар ном унших захиалга өгсөн бэ?
- Туул номыг хэд хоногоор авсан бэ?



Б. Үгсийг зөв дараалалд оруулан зүйр үг бүтээж, бичээрэй.

Усан

эхтэй

ухаан

эхтэй

далай

номноос

булгаас

далай



В. Харилцан ярианаас харьяалахын тийн ялгалтай үгийг түүж бичээрэй.

Дасгал 8



А. Эхийг уншаад асуултад хариулж бичээрэй.

Ном унших нь



Ном унших нь хүний сэтгэн бодох чадварыг хөгжүүлдэг. Ном уншвал толгой сэргэж, ой тогтоолт сайн болдог. Хүүхдүүд та нар зөв хурдан уншихын зэрэгцээ ойлгож унших нь илүү чухал. Номын санд бусдад саад болохгүй өөртөө унших хэрэгтэй. Хүүхэд бүр том болоод эрдэм номтой, ухаалаг сайн хүн болохын тулд ном их унших хэрэгтэй. Эрдэмтэй хүн даруу, их мөрөн дөлгөөн гэдэг үгийг байнга санаж яваарай.

Асуулт

- Ном уншихын ач тус юу вэ?
- Өөрийнхөө мэдэх номыг нэрлээрэй.
- Танай сургуулийн номын сан хаана байдаг вэ?
- Номын тухай ямар дуу, шүлэг, оньсого мэдэх вэ? Нэрлэж хэлээрэй.



Б. Дээрх асуултыг найзаасаа асууж, ярилцаарай.



В. Эхээс өөрт таалагдсан нэг өгүүлбэрийг дэвтэртээ бичээрэй.



Г. Дараах өгүүлбэрийг гүйцээж дэвтэртээ бичээрэй.

Ном унших нь хүний



Ном уншвал

Номыг унших хэрэгтэй.

Сайн хүн болохын тулд



Д. “-ы, -ий, ын, ийн” зөв залган бичихдээ богино эгшгийг гээж бичээрэй.



Е. Эгшиг нь гээгдсэн үг 5, гээгдээгүй үг 5-ыг бичээрэй. Тус бүрт өгүүлбэр зохиож бичээрэй.

Жишээлбэл:

зураг + ийг = зургийг

самбар + ын = самбарын

Дасгал 9



А. Шүлгийг уран уншаарай.



НОМ

Нар гарвал өдөр гэж
Сар гарвал шөнө гэж
Ус урсвал зун гэж
Цас орвол өвөл гэж
Хангай дэлхий лустай гэж
Хан хурмаст луутай гэж
Замбуулин эргэдэггүй гэж
Залуу хүн үхдэггүй гэж
Тааж итгэдэг байсан ч
Барин тавин таагддаггүй
Байгаль ертөнцийн нууцыг
Нам зөөлөн шивнэж
Ном надад тайлбарласан ...

Шүлгийг уншихдаа:

- Үгээ тогтооно.
- Зөв уншина.
- Уран уншина.
- Тод уншина.
- Дууны өнгийг тохируулан уншина.

Ч.Лхамсүрэн



Б. Доорх үгсийг ашиглан шүлэгт орсон эсрэг утгатай үгийг бичээрэй.

нар

өдөр

сар

зун

ус

өвөл

шөнө

цас



В. Үгийг ажиглаад холбоо үг болгон бичээрэй.

хангай

хан

дэлхий

ертөнц

нам

байгаль

зөөлөн

хурмаст



Г. Үгсийг зөв байрлуулж өгүүлбэр бүтээгээрэй.



нууцыг, ном, Байгаль, тайлбарласан, ертөнцийн, надад,



Д. Бүтээсэн өгүүлбэрээ асуух өгүүлбэр болгон бичээрэй.

АЖИЛ ХӨДӨЛМӨР

Зуралт талъ



зураач



барилгачин



тамирчин



оёдолчин



хөгжимчин



нягтлан бодогч




цагдаа



шүүгч



жүжигчин



бүжигчин



дуучин



инженер



үдээс өмнө



үдээс хойш



хүсэл мөрөөдөл



шаазан



гол гатлах



шидэх



хугалах



унагах



А. Харилцан яриаг хосоор уншаад, асуултад хариулж бичээрэй.



Сайн уу? найз аа.

Хаашаа явж байна вэ?

Дууны дугуйланд явж байна. Одоо 2 цагаас эхэлнэ. Чи хаашаа явж байна вэ?



Сайн, сайн уу?

Би сургууль дээрээ үдээс хойш монгол хэлний хичээлийн давтлагатай.

Чи том болоод ямар мэргэжилтэй болохыг хүсдэг вэ?

Би багш болохыг хүсдэг. Миний ээж багш. Аав нягтлан бодогч хүн дээ. Харин чи ямар мэргэжилтэй болохыг хүсдэг вэ?

Би дуучин болохыг мөрөөддөг. Миний аав хөгжимчин, ээж оёдолчин.

Сайхан юм аа. Нэртэй дуучин болоорой. За би явъя даа. Баяртай.

Баяртай.

Асуулт

- Туяа ямар дугуйланд явдаг вэ?
- Туяагийн дугуйлан хэдэн цагаас эхэлдэг вэ?
- Туул үдээс хойш ямар хичээлийн давтлагатай вэ?
- Туул ямар мэргэжилтэй болохыг хүсдэг вэ?



Б. Зураг дээрх мэргэжлийн нэрийг бичээд өгүүлбэр зохиогоорой.



Дархан + аас = Дарханаас

Үлгэр + ээс = үлгэрээс

Мягмар + аас = Мягмараас

**Богино эгшиг
гээгдэхгүй.**

бүжиг+ийн = бүжгийн

шатар+ын = шатрын

зураг+ийн = зургийн

**Богино эгшиг
гээгдэнэ.**

Дасгал 2



А. Эхийг уншаад асуултад хариулаарай.



Миний хүсэл мөрөөдөл бол ирээдүйд уул уурхайн инженерийн мэргэжилтэй болох юм. Уул уурхай хөгжвөл улс орон маань хөгжинө. Мөрөөдөлдөө хүрэхийн тулд би хичээл номдоо шамдан суралцах ёстой.

Бидний гол хөдөлмөр бол – сурах юм. Би уйгагүй хичээл номоо давтдаг. Энэ бол миний сайн тал юм. Энэ сайн чанар маань намайг мөрөөдөлд минь хүргэнэ гэдэгт итгэдэг. Би мөрөөдөлдөө хүрч сайн инженер болсноор сайхан амьдарна. Мөн эх орныхоо хөгжилд өөрийнхөө хувь нэмрээ оруулах болно.

Асуулт

- Чи ямар мэргэжилтэй болохыг хүсдэг вэ?
- Мөрөөдөлдөө хүрэхийн тулд яах ёстой вэ?
- Сайн хүний шинжийг нэрлээрэй.



Сайн хүн



Б. Өөрийнхөө мэдэх мэргэжлийн нэрийг жагсааж бичээрэй. Бүтээсэн үгсээ зөв дуудаж уншаарай.



В. “орчуулах, оршуулах” – үгийг оролцуулан өгүүлбэр зохиогоорой. Энэ хоёр үгийг харьцуулан уншаарай.



Г. Дараах үгэнд олон тооны нөхцөлүүдээс тохирохыг залгаж бичээрэй.

шүүгч тариачин уурхайчин	-чууд	-ууд	-үүд	-чуул
	-д	-чүүл	-с	-нар
				-чүүд



Д. Үгсийг зөв дуудан, уншаад өгүүлбэр зохиож бичээрэй.

эмч	сувилагч	тогооч	ажилтан
зураач	жолооч	малчин	зөөгч



Е. Дараах үгсэд дагавар, нөхцөлийг зөв залгаж бичээрэй.

зураач+ийн=
эмч+ийн=
жолооч+ийн=

тогооч+оос=
ажилтан+ы=
нисэгч+ийг=

зөөгч+өөс=
сувилагч+ийн =
малчин+аас=

Дасгал 3



А. Шүлгийг уншаад, ярилцаарай.

...Ахмад үеийн багш нарт
Хийхгүй ажил гэж байгаагүй
Хөгжим баривал дуучин
Клубт очвол жүжигчин
Багт гарвал ухуулагч
Байшин баривал инженер
Бүлээрсэн хүүхдэд эмч
Бүрэлгэсэн дайсанд шүүгч...

Ш.Сүрэнжав ("Багш" найраглалын хэсгээс)

Шүлгийг уншихдаа:



- Үгээ тогтооно.
- Зөв уншина.
- Уран уншина.
- Тод уншина.
- Дууны өнгийг тохируулан уншина.



Б. Багш мэргэжлийн тухай ярилцаад бичээрэй.



В. Зүйр үгийн цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээд, уншаарай.



Г. Дараах үгсийг зөв уншаад өгүүлбэрт оруулж бичээрэй.

дуучин

ухуулагч

шүүгч

тариачин

жүжигчин

худалдагч

сувилагч

багш



Д. Үсгүүдээр боломжит үгс бүтээж, өгүүлбэр зохиож бичээрэй.



Жишээлбэл: гэм



Е. Дараах мэргэжлийн хүмүүсийн өдөр тутам хийдэг ажлыг тоочин бичээрэй.

малчин

зөөгч

сувилагч

Дасгал 4



А. Зургийг ажиглаад тайлбарлаж ярилцаарай.



Жишээлбэл: Хүнийг хэн гэж асууна. Хэн хог хаясан бэ?



Б. Өгүүлбэр доторх үгсийг ямар асуултад хариулагдах эсэхийг бичээрэй.

Өсөхөд шүд цагаан
Өтлөхөд үс цагаан
Үхэхэд яс цагаан

Хөх тэнгэр үүлсээр баян
Хөрст газар үндсээр баян
Хөлгүй далай загасаар баян



В. Загварыг ашиглан өгүүлбэр зохион бичээрэй.

Жишээлбэл:

Аав ээж хоёр өчигдөр хөдөөнөөс ирсэн.

<input type="text" value="Хэн"/>	<input type="text" value="юутай"/>	<input type="text" value="юугаар"/>	<input <="" td="" type="text" value="яав?"/>
<input type="text" value="Хаана"/>	<input type="text" value="ямар"/>	<input type="text" value="юу"/>	<input <="" td="" type="text" value="байна?"/>
<input type="text" value="Яагаад"/>	<input type="text" value="хэн"/>	<input type="text" value="хаана"/>	<input <="" td="" type="text" value="яагаагүй вэ?"/>
<input type="text" value="Хэн"/>	<input type="text" value="хаанаас"/>	<input type="text" value="хэрхэн"/>	<input <="" td="" type="text" value="яах вэ?"/>



Г. Үгийн утгыг ойлгож аваарай. Цэгийн оронд нөхөж бичээрэй.

хэр



хэр хэмжээ

Эндээс танай сургууль
хал байдал вэ?

хир



хир буртаг

..... гаранд нян
үрждэг.

Дасгал 5



А. Эхийг уншаад асуултад хариулж бичээрэй.

Ах дүү гурвын эв нэгдэл

Ах дүү гурав амьдарч байв. Нэг өдөр явж байгаад бага дүү нь гурван хэсэг алт олж, хоёр ахдаа нэг нэгийг өгчээ. Тэд завинд сууж, гол гатлан явтал дүү нь гартаа барьсан алтаа гэнэт усанд шидчихжээ.

- Яагаад үнэтэй алтыг ус руу шидэж байгаа юм бэ? гэж гайхан хоёр ах нь асуутал отгон дүү нь:

- Алт олохоос өмнө ах нарыгаа хайрлаж байсан сэтгэл минь одоо өөрчлөгдөх гээд байна. Алт олсноос хойш та хоёрыг үзэн ядаж, би ганцаараа бүх алтыг авах ёстой гэж харамсах сэтгэл төрөх боллоо. Ийм учраас алтаа усанд шидсэн юм гэжээ.

- Үнэхээр чиний хэлдэг зөв шүү! гээд хоёр ах нь алтаа усанд хаяж:

- Гэр бүл эв найртай байвал ядуу байсан ч жаргалтай байна.

Ах дүүгийн эв эвдэрвэл баян байсан ч ашиггүй гэсэн аавын сургаал санаанд орлоо гэв. Түүнээс хойш ах дүү гурав эв найртай амьдарсаар байв.

Асуулт

- Бага дүү нь юу олсон бэ?
- Бага дүү нь яагаад алтыг ус руу шидсэн бэ?
- Аав нь ямар сургаал үг хэлсэн бэ?



Б. Эхээс тохирох үгсийг ялгаж бичээрэй.

Тоо заасан үгс	Үйл хөдлөлийг нэрлэсэн үгс
.....
.....
.....



В. Үгсийг зөв дуудан уншаад өгүүлбэр зохиож бичээрэй.

бөмбөг шидэх



асуудал шийдэх

бага дүү

багийн дарга



Г. Зүйр үгийг цээжлээрэй. Утга төстэй зүйр үг нэгийг олж бичээрэй.



Дасгал 6



А. Харилцан яриаг уншаад асуух өгүүлбэрийг ялгаж бичээрэй.

Сайн уу? Болор оо.

Чи гэртээ байна уу?

Чи юу хийж байна вэ?

Би ч бас гэртээ. Хичээлээ давтаад сууж байна.

Тийм ээ, сайн хүн болж, аав ээжийнхээ ачийг хариулна даа гэж боддог.

Би монгол хэлний даалгавраа хийж байна.



Сайн, сайн уу? Туяа.

Тийм ээ, би гэртээ байна.

Би гэрийнхээ ажлыг хийж байна.

Бидний гол хөдөлмөр бол сайн сурч, аав ээждээ туслах юм даа. Чи юу гэж бодож байна вэ?

Би ч бас чамтай санал нэг байна.

Чи юуны хичээлээ давтаж байна вэ?

За хичээлээ давт даа. Баяртай.



Б. Туяа Болор хоёрын хийж буй үйл ажил хөдөлмөр мөн үү? Тайлбарлаж яриарай.



В. Та нар ямар ямар хичээлээр юу юу үздэг вэ? Дэвтэртээ жагсаан бичээрэй.

Жишээлбэл: Монгол хэлний хичээл - үг, өгүүлбэр, дүрэм, гэх мэт.

Монгол хэл

.....

.....



Г. Өгүүлбэрүүдийг уншаад мэргэжил заасан үгсийг ялгаж бичээрэй.

Сургуульд багш, нийгмийн ажилтан, эмч, номын санч ажилладаг.

Эмнэлэгт сувилагч, эмч, нягтлан бодогч ажилладаг.

Теарт хөгжимчин, дуучин, бүжигчин, жүжигчин ажилладаг.

Цайны газарт тогооч, зөөгч, худалдагч ажилладаг.



Д. Дээрх мэргэжил заасан үг тус бүрт асуух өгүүлбэр зохиож бичээрэй.

Мэргэжил заасан үгс	Асуух өгүүлбэр
.....?
.....?
.....?



Е. Үгсийг харьцуулж, зөв дуудан уншаад, хүүрнэх өгүүлбэр зохиож бичээрэй.

өрөө

өөрөө



А. Эхийг уншаад асуултад хариулж бичээрэй.

Боловсролыг хэзээ олж авах вэ?

Найзууд аа! Та нар хэзээ юуг суралцах ёстойгоо ер нь мэдэх үү? Яг өнөөдөр чи юу сурсан байх ёстой ба түүнийгээ заавал эзэмшсэн байхын ач тусыг мэдэх үү?

Аливаа бүх зүйлд тогтоосон цаг хугацаа байдаг ажээ. Цэцэрлэгт бяцхан жаалууд урлагийн, ой тогтоолтын дасгалын үндсийг сурдаг. Дуу, шүлэг, зураг, баримлын шавар тэр бүхний анхны үндэс болдог. Бага ангид цагаан толгойн үсгийг тооны цифртэй сурснаар эрдэм ном суралцахад хэрэглэх багажаа гартаа авч байна гэсэн үг. Дунд ангид ерөнхий шинжлэх ухаан, урлаг соёлын анхны мэдэгдэхүүнийг суралцдаг ертөнцийг таних цонхоо нээж байгаатай адил. Харин оюутан болж, их сургуульд орохоороо “Энэ амьдралд хэн байх вэ?” гэсэн асуултад хариулахаар суралцаж, тэр онцлогтоо тохирсон шаардлагатай боловсролыг олж байгаа юм шүү дээ.

Хэрэв эдгээр цаг хугацааг хөвөрсөн гинж гэж үзвэл, өнгөрсөн хугацаанд аль нэг зүйлийг нь тухайн цагт нь хийгээгүй, суралцаагүй, мэдлэг олж аваагүй байсан бол гинжин хэлхээг юугаар орлуулах вэ? Гинж тасрахтай л адил. Тиймээс өнөөдөр суралцах ёстой зүйлсээ суралцахын ач холбогдлыг тунгаан бодож, хичээнгүйлэн хөдөлмөрлөх нь чухал юм.

Асуулт

- Боловсролыг хэзээ олж авах вэ?
- Цэцэрлэгт юу сурдаг вэ?
- Бага, дунд ангид юу юу сурдаг вэ?
- Оюутан болоод юу сурах бол?
- Чи ирээдүйд ямар мэргэжилтэй болох вэ? Түүндээ хэрхэн хүрэх арга замаа хуваалцана уу.



Б. Загварыг ашиглан өөрийн сурах арга барилаас хуваалцаж яриарай.





В. Гинжин хэлхээнд ямар үгс байна вэ? Бичээрэй. Цааш үргэлжлүүлэн 5-6 үг бичээрэй.



сурал → цах илга ан ги шүү



Г. Зүйр цэцэн үгийг уншаад цаг хугацааны үнэ цэнг хэрхэн илэрхийлснийг тайлбарлаж яриарай.



Дасгал 8



А. Харилцан яриаг хосоороо уншаад, асуултад хариулж бичээрэй.



Сайн байна уу?
Дэлгэр ээ.

Сайн сайн уу?



Чи хаашаа явж
байна вэ?

Би аавын ажлын
газар луу явж
байна.

Аав чинь юу
хийдэг вэ?

Аав эмнэлэгт мэс
заслын эмч хийдэг.

Би ээжийн ажлын
газар луу явж
байна.

Харин чи хаашаа
явж байна вэ?

Ээж чинь юу
хийдэг вэ?

Миний ээж нэгдүгээр
сургуульд бага ангийн
багшаар ажилладаг.

За баяртай.

За за.
Би явъя даа.

Асуулт

- Дэлгэр хаашаа явж байсан бэ?
- Дэлгэрийн аав хаана ажилладаг вэ?
- Хонгорзул хаашаа явж байсан бэ?
- Хонгорзулын ээж хаана ажилладаг вэ?
- Хонгорзулын ээж ямар мэргэжилтэй вэ?
- Дэлгэрийн аав ямар мэргэжилтэй вэ?



Б. Эмч, багш мэргэжлийн төрлүүдийг нэрлэж дэвтэртээ бичээрэй.

Багш	Эмч
Химийн багш	Шүдний эмч
.....
.....
.....

Дасгал 9



А. Харилцан яриаг уншаад асуултад хариулаарай.

Бусдын хөдөлмөрийг хүндлээрэй

- Ээж ээ, энэ хүмүүс юу хийгээд зогсож байгаа юм бол оо? Ажилгүй юм байх даа?
- Хүү минь тэгж хэлж болдоггүй юм. Энэ хүмүүс бүгд ажлаа хийж байна.
- Юу хийж бүтээдэг юм бол? Харагдахгүй юм.
- Биднийг тав тухтай, эрүүл сайхан орчинд амьдруулахын тулд маш олон хүмүүс хөдөлмөрлөдөг юм шүү.
- Барилгачин бол байшин барьдаг, тогооч хоол хийдэг, цэцэрлэгч мод зүлэг тарьдаг. Харин энэ хүмүүс?
- Аюул осолгүй зорчуулахын тулд замын цагдаа замын хөдөлгөөнийг зохицуулдаг. Халуун хүйтэн устай тавтай байлгахын тулд засварчин ажилладаг. Гудамж талбайг цэвэр цэмцгэр байлгахын тулд үйлчилгээний ажилтнууд өглөө эртлэн цэвэрлэгээ хийдэг юм шүү дээ.
- Аан за ойлголоо, ээж ээ.
- Тиймээс бид бусдын хөдөлмөрийг хүндэлж, зөв амьдрах хэрэгтэй.

Асуулт

- Ээж хүү хоёрын ярианы сэдэв юу вэ?
- Ямар ямар мэргэжлийн талаар ярилцсан бэ?
- Та нар гэртээ ямар ямар ажил хийдэг вэ?



Б. Чи юу хийж бүтээхийг хүсдэг вэ? Жагсаан бичээрэй.

Ойрын төлөвлөгөө

Хэтийн төлөвлөгөө

.....
.....
.....

.....
.....
.....



В. Зургийг ажиглаад хэн юу хийдгийг бичээрэй.



Г. Өгүүлбэрийг асуух, анхааруулах, хүүрнэх өгүүлбэр болгон бичээрэй.

Бусдын хөдөлмөрийг хүндэл



Д. Тохирох нөхцөлүүдийг залган бичээрэй.

Хөдөлмөр

-ЫН

-аар⁴

-ЫГ

-Г

-ИЙН

-Н

-ТАЙ⁴

-аас⁴

-ИЙГ

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН

Зуралт толь



тал



хангай



ГОВЬ



цаст уул



тэнгэр



хормой



хөөх




ул



гарц



зогс замын тэмдэг



ЗОГСООЛ



замын тэмдэг



уулзвар



замын цагдаа



явган хүний зам



замын түгжрэл



замын хаалт



шатахуун



гэрлэн дохио



явган зорчигч



А. Харилцан яриаг анхааралтай уншаад даалгаврыг ажиллаарай.



Сайн, сайн уу? Эгшиглэн.

Чи хаанаас ирсэн бэ?

Монгол оронд анх удаа ирж байгаа юу?

Японоос хэзээ ирсэн бэ?

Чи Японд төрсөн үү?

Монгол орныг хэр сайн мэдэх вэ?

Манай Монгол орон өндөр уултай, уудам талтай, цэлмэг тэнгэртэй, цэнгэг устай. гурван сая гаруй хүн амтай. Үнэхээр сайхан нутаг.

За, тэгээрэй. Баяртай.

Сайн уу? Болд оо.

Би Японоос ирлээ.

Тийм ээ.

Өчигдөр ирсэн.

Үгүй ээ, би гурван настайдаа Японд очсон.

Сайн мэдэхгүй ээ.

Ямар сайхан юм бэ? Би зунжингаа аялна. Япон орныхоо тухай дараа ярьж өгнө.

Баярлалаа. Баяртай.



Б. Хэрвээ чи Эгшиглэнгийн оронд байсан бол Болдоос юуны тухай асуух вэ? Яриарай.



В. Уншаад асуулт зохиож бичээрэй.

Асуулт	Хариулт
.....?	Болд өчигдөр ирсэн.
.....?	Эгшиглэн Монголд амьдардаг.
.....?	Монгол орон 3 сая гаруй хүн амтай



Г. Дараах үгсийн утгыг ярилцаад дэвтэртээ жишээ өгүүлбэр бичээрэй.

Жишээлбэл: Монгол улс 3 сая гаруй хүн амтай.



гаруй - барагцаалсан илүүдэл хэмжээ



орчим - ойролцоо, хавьцаа, шахуу

Дасгал 2



А. Дараах үгсийг давтаж уншаарай. Уншихдаа үгсийг зөв дуудаж, нүдлэн тогтоогоорой.

өндөр уултай



уудам талтай



цэлмэг тэнгэртэй



цэнгэг устай



Б. Дээрх үгээс цэгийн оронд нөхөж дэвтэртээ бичээрэй.

Бүргэд шувуу үүрээ засдаг.

Шувууд дүүлэн ниснэ.

Загас жаргалтай сэлнэ.

Таван хошуу мал дураараа бэлчинэ.



В. Зургийг ажиглаад холбоо үг үүсгээд дэвтэртээ бичээрэй.



Г. Нөхцөлийг залгаж бичээд, ярилцаарай.

хурга+ ы=

газар + ын=

тэнгэр+ ийн=

санал+ аа=



Д. Жишээг ажиглаад үгийн утгыг ялгасан өгүүлбэр зохион бичээрэй.

зүг чигээ алдах



төөрөх



төрөх

хорвоод мэндлэх



-д явж байгаад



..... өдрийн



хийлээ.

Дасгал 3



А. Шүлгийг цээжлээд, уран тод уншаарай.

Монгол орон

Цагаан цасан малгайтай
Ногоон модон хүрэмтэй
Хөх усан хормойтой
Баян хангай уул минь



Маш дэлгэр хангай минь
Мал сүргээр дүүрэн
Малчин олон Монголчууд
Жаргал цэнгэлээр дүүрэн


Ц.Дамдинсүрэн



Б. Малгай, хүрэм, хормой гэсэн үгсийг шүлэгт юутай адилхан гэж дүрсэлсэн бэ? Яагаад? Хариулж бичээрэй.





В. Үгсийн утгын ялгааг ойлгон зөв дуудаж уншаарай.



Г. Зургийн оронд нөхөж бичих үгс: ул, хөх, цаас, хөөх, цас, уул

Өвөл болж,  оров. Манай ангийн хүүхдүүд  -аар цэцэг хийв.

Ахын гутлын  том. Монгол Улсын хамгийн өндөр  Алтай

Таван Богд юм. Надад  өнгийн дээл байдаг.



Д. Үгийн утгыг ойлгож аваарай. Цэгийн оронд нөхөж бичээрэй.



ИЧИХ



Өвөл болж,  ичээндээ оров.

Тэмүүлэн найздаа худал хэлсэндээ  .

Дасгал 4



А. Эхийг уншаад асуултад хариулаарай.

Хөхөөнөөс ичсэн нь

Оюун, Сувд хоёр ой руу явав. Тэд өвсөн дээр суугаад хооллохоор болжээ. Охид гэрээсээ өрөм, ааруул, боорцог авч ирсэн байлаа. Тэд хооллож суухдаа хөхөө донгодохыг сонсов. Сайхан дуунд сэтгэл татагдсан охид хэсэг чимээгүй суулаа. Хөхөө донгодохоо болих үед тэд явахаар босов.

Оюун боорцогны үлдэгдлийг цаасанд ороож, бутан доогуур хаяв. Харин Сувд үлдэгдлээ цуглуулж цүнхэндээ хийжээ.

- Чи яагаад энэ хогийг авч явж байгаа юм бэ? Бут руу шид. Ойд бид хоёр л байгаа. Хэн ч харахгүй гэж Оюуныг хэлэхэд,

- Хөхөөнөөс ичиж байна гэж Сувд аяархан хариулжээ.

Асуулт

- Охидыг хэн гэдэг вэ?
- Тэд хаашаа явсан вэ?
- Охид хаана хооллохоор суусан бэ?
- Тэд гэрээсээ юу юу авчрав?
- Тэд юу олж харсан бэ?
- Хооллосны дараа охид ямар үйлдэл хийсэн бэ?
- Хэний үйлдэл зөв бэ? Яагаад?



Б. Үйл явдлыг зургийн дагуу яриарай.

Эхлээд



Дараа нь



Эцэст нь



В. Оюун, Сувд нарыг дуурайн дүрд тоглоорой.




Г. Үгсийн утгын ялгааг ойлгон зөв дуудан уншаарай. Өгүүлбэрийг гүйцээн бичээрэй.



цас орох

цаасанд ороох



Цас ороход хүүхдүүд ороов.



хийв. Эгч хийсэн хоолоо



-д

Дасгал 5



А. Уриалгыг харьцуулан уншиж асуултад хариулан бичээрэй.

ХЭВШИЛ БОЛГОЁ!

Найзууд аа!




Байгалиа хайрлаж, байгальдаа хог хаяхгүй зугаалдаг болцгооё!

2022.04.05.

5 дугаар сургуулийн
4^а ангийн сурагч Б.Мөнх

ХОВД ГОЛОО ХАЙРЛАЯ!

Хүүхдүүд ээ!



Голын цэнгэг усанд хог хаяхгүй, цэвэр байлгахыг уриалж байна.

Цэвэр усны нөөц болсон Ховд голоо хайрлаж хамгаалъя.

2022.04.05.

5 дугаар сургуулийн 4^а ангийн
сурагчид

Асуулт

- Гарчгаас юунд уриалсныг ажиглаарай.
- Хүүхдүүд хэнд хандаж, юу гэж уриалсан байна вэ?
- Хүүхдүүд уриалга гаргах болсны учир юу вэ?



Б. Асуултын тэмдэгтэй зургийг ашиглан ангийнхандаа хандаж юу гэж хэлж болох вэ? Ярилцаарай.



В. Уриалгын бүтцийг ажиглан уншаад, асуултад хариулж бичээрэй.

Эхлэл

УРИАЛГА

Хүүхдүүд ээ!

- Хогоо хогийн саванд хийж хэвшицгээе!
- Ангийн хогийн савыг зөв ашиглая!
- Хогоо хогийн саванд хаяж, ангиа цэвэр байлгахыг уриалж байна.

Гол хэсэг

Төгсгөл

**ЦЭВЭРЧ БАЙДЛЫГ
ӨӨРӨӨСӨӨ ЭХЛЭ!**

2022.04.25 Өлгий хот

Асуулт

- Хэнд хандсан бэ?
- Юунд уриалсан бэ?
- Юу гэж уриалсан бэ?
- Хэрхэн дүгнэсэн бэ?
- Хэзээ вэ?
- Хаана вэ?



Г. Дараах өгүүлбэрийг анхааруулах, захирах өгүүлбэр болгон бичээрэй.

Ус хэмнэх, мод тарих, байгаль хамгаалах.

Үлгэрлэвэл: хог хаях
Анхааруулах өгүүлбэр
Хог хаяж болохгүй шүү!

Захирах өгүүлбэр
Хог бүү хая!

Д. Үгсийг ашиглан байгаль хамгаалах талаар уриалга бичээрэй.

Ашиглах үгс: хамгаалъя, болцгооё, хайрлая

Е. Зургийг ажиглаад тохирох үгсийг нөхөж бичээрэй.



найз



найзууд



.....



.....



.....



.....



.....



.....

Дасгал 6



А. Танилцуулгыг уншаад, асуултад хариулж бичээрэй.

Тараг бол эм

Тараг нь яс бэхжүүлэх, хоол шингээх, нойр хүргэх зэрэг олон талын ач холбогдолтой цагаан идээ юм. Тараг сүүнээс илүү сайн шингэдэг. Өглөө бүлээн тараг увал эрүүл мэндэд нэн тустай.



Үйлдвэрлэсэн он, сар, өдөр



Заавар

ОРЦ НАЙРЛАГА:
Үнс/сарлагы тослог тохируулсан сүү, цэвэр өсгөврийн хөрөнгө.

ХЭРЭГЛЭХ ЗААВАР:
Шууд хэрэглэх эсвэл бусад хоол хүнсний амтлахад

ХАЛГ: Баян-Өлгий аймгийн Буянт сумын Жасрал Ажлааг хөрөнгийн сүү боловсруулах хөрөг төв үйлдвэрлэл, УТАС: 9946-2775, 9511-5226

100гр бүтээгдэхүүнд /тооцолгоо хамар/

Тос	2.5%-с доошгүй.
Уураг	3.2%-с доошгүй
Нүүрс уе	4.7%.
Илчлэг	55-65 ккал

ХАДГАЛАХ ГОРИМ:
0-8°C хэмэ 10 хоног хүртэл хадгалах

ХАРШЛЫН МЭДЭЭЛЭЛ:
Үнсний сүүнд харшлагтай бол хэрэглэх тохиромжгүй.

MNS 4229:2015
8 658 000 247 042

Асуулт

- Хугацаа дууссан бүтээгдэхүүн хэрэглэвэл юу болох вэ?
- Яагаад зааврыг унших ёстой вэ?
- Зааврын юу юу нь илүү чухал вэ?



Б. “Гүемхэн” тарагны танилцуулгад ямар мэдээлэл өгснийг тоочин яриарай.



Хадгалах нөхцөл

Ач тус

Орц найрлага

Үйлдвэрлэсэн он, сар, өдөр

Хэрэглэх заавар



В. Мэдээллүүдийг ашиглан “Зөв” аарцны танилцуулгыг бичээрэй.

Ашиглах үгс: Дархлаа сайжруулах, ханиад томуу, халуун аарц, уураг ихтэй, С, А, В1, В2, Е, РР аминдэм



Г. Үгийн утгыг ойлгож аваарай. Цэгийн оронд нөхөж бичээрэй.

уураг



шим тэжээлт бодис

Өндөр ихтэй хунсний бүтээгдэхүүн юм.

уурга



адуу мал, загас барих саваа

Аав заласанг авч явдал.

Дасгал 7



А. Шүлгийг цээжээр уран уншаарай.

Улаан гэрэл аслаа, аслаа
 Урдаас машин ирлээ, ирлээ
 Найзууд аа, найзууд аа
 Улаан гэрэл аюултай шүү!

Шар гэрэл аслаа, аслаа
 Сааруулж хурдаа хаслаа, хаслаа
 Багачууд аа, багачууд аа
 Ногоон гэрэл хүлээгээрэй!

Ногоон гэрэл аслаа, аслаа
 Цагаан гарцаар гарлаа, гарлаа
 Хүүхдүүд ээ, хүүхдүүд ээ
 Ногоон гэрэл аюулгүй шүү!



Асуулт

- Ямар гэрэл асахад анхааралтай байх ёстой вэ?
- Гэрлэн дохиогүй ч гарцаар зам хөндлөн гарч болох уу?
- Шар гэрлээр гарч болох уу?





Б. Багана болон мөрийг тохируулан хэлээрэй.

Улаан гэрэл	Ногоон гэрэл	Шар гэрэл	
			явна.
			хүлээнэ.
			зогсоно.



В. Замын цагдаа хүүд юу гэж хэлсэн бол? Өгүүлбэр зохиож дэвтэртээ бичээрэй.



.....!

.....!

.....!

.....!

Дасгал 8



А. Эхийг уншаад нөхцөлийг залгаж дэвтэртээ бичээрэй.





Хүүхэд+үүд ээ! Та нар сургууль+д+аа ир+х+д+ээ зам хөндлөн гар+даг уу? Зам хөндлөн гар+х үе+д явган хүн+ий гарц+аар гар+аарай. Зам руу ор+х+ын өмнө зам+ын хоёр тал+ыг сайн хар+на. Машин зам дээр хэзээ ч гүйж, тогло+ж бол+х+гүй! Зам+ын хөдөлгөөн+д соёлтой ор+лц+ж сур+цгаа+я.



Б. Дээрх эх уриалга мөн үү? Яагаад?



В. Зургаас сайн, муу үйлийг ялган бичээрэй.



Г. Зурагт тохирсон уриалга хэлээрэй.



Д. Үгийн утгыг ойлгож аваарай. Цэгийн оронд нөхөж бичээрэй

шар → өнгө шар → эр үхэр шар → өвчин

1. Эгч өнгөтэй даашинз өмсөх дуртай.
2. Халдварт гэдэг нь бохир гарын өвчин юм.
3. Сүргийн манлайг бух, нас бие гүйцсэн эр үхрийггэнэ.



Е. Зургийг ашиглан асуултын дагуу яриарай.

- Хэрэв чи улбар шар байшинд амьдардаг бол сургуульдаа хэрхэн хүрэх вэ?
- Хэрэв чи бор байшинд амьдардаг бол банк руу хэрхэн очих вэ?



ЭРҮҮЛ АМЬДРАЛ

Зургалт томь



уурлах



инээх




гомдох



баярлах



дасгал хийх



алхах



гүйх



ам зайлах



инээмсэглэл



гунигтай



хийжүүлсэн ундаа



нөөшилсөн хүнс



хорхой



жүүс



утсан мах



хуурах



жаргал



зовлон



эрч хүчтэй



хоолны цэс



А. Анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

Бид эрүүл амьдрах нь чухал. Эрүүл амьдрахын тулд бид хамгийн түрүүнд зөв хооллох хэрэгтэй. Хүний өдөр тутмын хоол хүнс нүүрс ус, уураг, өөх тос, амин дэмээр баялаг байвал сайн.

Өдөр бүр дасгал хөдөлгөөн хийх, явган явах, гүйх биед тустай. Хорин хоёр цагаас өмнө унтвал, өглөө сэргэг босож, өдрийн турш эрч хүчтэй байх болно. Инээмсэглэл бол аз жаргалын эхлэл. Бусдад үргэлж талархаж баяр баясгалан бэлэглэж байгаарай. Эрүүл амьдралын хэв маяг нь таныг урт насалж, илүү жаргалтай амьдрахад тусална.



Б. Уншаад асуулт зохиож бичээрэй.

Асуулт	Хариулт
.....?	Би орой 22 цагт унтдаг.
.....?	Идэвхтэй хөдөлгөөн гэдэг нь дасгал хийх, алхах, гүйх зэрэг юм.
.....?	Өндөг, сүү, жимс, ногоо нь амин дэмээр баялаг хүнс мөн.



В. Чиний бодлоор эрүүл амьдрахад юу юу хэрэгтэй вэ? Ярилцаарай.



Г. Доорх үгсийг уншаад, цэгийн оронд зурагт тохирох үгийг бичээрэй.

Ашиглах үг: Баярлах, уурлах, инээх, гомдох, уучлах, уйлах, талархах, магтах



.....



.....



.....



.....



Д. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй.

Эрүүл амьдрахын тулд бид хамгийн түрүүнд зөв хэрэгтэй. Өдөр бүр дасгалхийх, явах, биед тустай. бол аз жаргалын эхлэл. Бусдад үргэлж талархаж бэлэглэж байгаарай.



Е. Хуулж бичихдээ өгүүлбэрийн төгсгөлд тохирох тэмдгийг тавиарай.

Хорин хоёр цагаас өмнө унтаж хэвшээрэй

Явган явах идэвхтэй хөдөлгөөн мөн үү

Хийжүүлсэн ундаа хэрэглэж болохгүй шүү

Хүнсний бүтээгдэхүүн худалдаж авахдаа хадгалах хугацааг нь хардаг



Дасгал 2



А. Шүлгийг уран уншаарай.

Шүдээ угаая

Хөөрхөн гартаа сойзоо бариад
Хөвсгөр оогоо дээр нь түрхээрэй
Амандаа усаа балгаад



Ахин дахин зайлаарай

Баруун зүүн дээшээ доошоо

Бяцхан шүдээ угаагаарай

Өглөө орой өдөр бүр

Бяцхан шүдээ угаагаарай

Хэрэв шүдээ угаахгүй бол

Хорхой чамайг өвтгөнө шүү

Эрүүл цагаан шүдтэй бол

Энэ бие чинь жаргалтай

Баруун зүүн дээшээ доошоо



Бяцхан шүдээ угаагаарай

Өглөө орой өдөр бүр

Бяцхан шүдээ угаагаарай



Б. Зүйр үгсийг уншаад утгыг нь ярилцаарай. Дууны утгатай тохирох зүйр үгийг хуулж бичээрэй.



В. Үгийг зөв байрлуулан зүйр үг бүтээгээрэй. Мөр мөрөөр нь уншиж утгыг нь ярилцаарай.

Эрүүл

ухаан

биед

оршино

саруул

бол

Өргүй

баян

Өвчингүй

жаргал

бол



Г. Хоёр багананд байгаа холбоо үгийг харьцуулж уншаарай.

шүд угаа
оо авчир
сойз ав
хоол ид



шүдээ угаа
оогоо авчир
сойзоо ав
хоолоо ид

Дасгал 3



А. Уншаад даалгаврыг ажиллаарай.

Дэлгүүрт

Өнөөдөр миний дүүгийн төрсөн өдөр. Ээж бид хоёр бялуу авахаар хүнсний дэлгүүрт очив. Амралтын өдөр учраас дэлгүүрт хүн ихтэй байлаа. Бид бараагаа цуглуулж дуусаад, тооцоо хийхээр касс дээр очиход ээж надад:



- Миний хүү том болж дээ. Авсан бараануудын хугацаа, орц, найрлагыг хэлж өгч мөн ч их тус хүргэлээ гэв. Тооцоо хийхээр ээлжээ хүлээсэн хүмүүс дарааллаар зогсож байлаа. Ээжээсээ магтаалын үг сонссон би ээлжээ хүлээлгүй бусдын өмнө орж тооцоо хийхийг бодов.

Гэнэт хэн нэгэн миний мөрнөөс татах шиг болов. Би сандран эргэж харвал ээж минь байлаа. Ээжийнхээ ийм ууртай байхыг урьд өмнө харж байсангүй. Ам нээлгүй, ээлжээ хүлээж зогссоор байв. Энэ үед өөрийнхөө ямар буруу зүйл хийснийг ухаарсан юм. Бидний ээлж ч ирж, тооцоогоо хийв.




Б. Уншаад асуулт зохиож бичээрэй.

Асуулт	Хариулт
.....?	Өнөөдөр миний дүүгийн төрсөн өдөр.
.....?	Ээж хүү хоёр бялуу авахаар хүнсний дэлгүүрт очив.
.....?	Тооцоо хийхээр касс дээр очлоо.



В. Зургийг ажиглаарай. Хүнсний дэлгүүрээс бараа худалдаж авахад юуг анхаарах вэ? Яриарай.



Г. Эдгээр тасгуудыг юу гэж нэрлэдэг вэ? Өөр ямар ямар тасаг байдаг вэ? Дэвтэртээ бичээрэй.

Дасгал 4



А. Уншаад асуултад хариулж бичээрэй.

Бөөрөнхий

Баатар хүү хотын нэгэн сургуулийн дөрөвдүгээр ангид сурдаг. Бүгд түүнийг “Бөөрөнхий” гэж нэрлэдэг байв. Түүний дүр төрх бөмбөгийг санагдуулна. Түүний өвөө нь эрдэмтэн хүн юм. Өвөө нь ач хүүдээ хайртай тул байнга ном уншихыг зөвлөдөг байв. Баатар хүү ч ном унших маш их дуртай. Нэг өдөр Баатар өвөө дээрээ гунигтай ирэв.

- Юу болсон бэ? гэж өвөө нь асуухад:

- Биеийн тамирын хичээл дээр муу дүн авлаа. Би дасгал хийж чадаагүй гэв.

- Чи биеийн тамираар хичээллэх хэрэгтэй байсан гэж өвөө нь хэлэв.

- Үгүй, би эрдэм номтой мундаг хүн болно. Надад биеийн тамир хэрэггүй гэж Баатар хариулав.

- Өвөө нь дасгал хөдөлгөөний тухай номыг өгч, уншихыг зөвлөв. Баатар өвөөгийнхөө өгсөн номыг уншиж биеийн тамираар хичээллэж эхлэв. Нэг сар өнгөрлөө. Энэ үеэр Баатар “Бөөрөнхий” байхаа больж, жингээ хасаж илүү өндөр болжээ. Түүнийг биеийн тамирын багш магтав. Тэр гэртээ баяртай ирлээ.

Асуулт

- Баатарыг яагаад “Бөөрөнхий” гэж нэрлэдэг байсан бэ?
- Баатар хэн болохыг хүсдэг байсан бэ?
- Баатар юу хийх дуртай байсан бэ?
- Баатар биеийн тамирын хичээлд яагаад муу дүн авсан бэ?
- Баатар яаж өөрчлөгдсөн бэ?



Б. Зургийн үйл явдалд тохирох тус бүр нэг өгүүлбэр зохиож бичээрэй.



Эхлээд



Дараа нь



Эцэст нь



В. Харилцан яриаг гүйцээж бичээрэй. Уншихдаа Баатарын үгийг нөхөж уншаарай.



.....

Би биеийн тамирын хичээл дээр муу дүн авсан.

.....

Яагаад гэвэл би дасгал хийж чадаагүй.



.....

Үгүй, та мэднэ биз дээ. Би бол эрдэмтэй, номтой хүн болно.

.....

Надад биеийн тамираар хичээллэх хэрэг байхгүй.



Г. Найзтайгаа биеийн тамирын ямар төрлөөр хичээллэдэг талаар харилцан ярилцаарай. Жишээлбэл:

- Болд чи дугуй унаж чадах уу?
- Чадна. Би ноднин дугуй унаж сурсан. Би бас хөл бөмбөг, сагсан бөмбөг сайн тоглодог.
- Тийм үү? Би даам тоглож чаддаг. Одоо шатар тоглож сурч байгаа. Өвөөтэйгээ тоглож эхний өрөг хожигдож, хоёр дахь өргөө тэнцэв.



Д. Нөхцөлийг зөв залгаж бичээрэй. Яаж бичсэнээ ярилцаарай.

Хүний нэр Баатар



Баатар



баатар – эр зоригтой хүн

Өнөөдөр миний ах Баатар+ын төрсөн өдөр. Би Икей баатар+ын тухай өгүүллэг уншив. Төмөр+ийн номыг авчир. Өвөө төмөр+ийн хайчаар төмөр хайчлав. Манайд гэрэл +ийн байцаагч ирэв. Эгч Гэрэл +ийн даашинзыг индүүдэв.



Е. Үгийн утгыг ойлгож аваарай. Цэгийн оронд нөхөж бичээрэй.

өрөг



шатырын өрөг

Би шатырын тэмцээнд зургаан
..... тоглов.

өргө



дээш болгох

Хүнд цүнхсийг
хэцүү.

Дасгал 5



А. Хоол хүнсний тухай мэдээллийг уншаарай.

ЦУВРАЛ 4 **СҮРГУУЛИЙН ХҮҮХДИЙН ХООЛОНА ХОРИГЛОХ ХҮНС:**
Өөх тос, давс, сахар ихтэй хүнсний бүтээгдэхүүн. **ТУХАЙЛБАЛ:**

1 Чихэр, шоколад, жигнэмэг, бялуу

2 Хийжүүлсэн ундаа, кофе, какао

3 Давсалсан, утсан, ноошилсон бүтээгдэхүүн

4 Хуурч хайрсан (Транс тос агуулсан) бүтээгдэхүүн

facebook | twitter | youtube

ЦУВРАЛ 2 **ХҮҮХДИЙН ХООЛОНД:**

ЭРҮҮЛ ХҮНС (ХЭРЭГЛЭХ)

- Сүү цагаан идээ
- Мал, загас, шувууны мах
- Жимс, жимсгэнэ
- Олон урт тарианы гурилан бүтээгдэхүүн
- Хүнсний ногоо

ЭРҮҮЛ БУС ХҮНС (ХЭРЭГЛЭХГҮЙ)

- Чихэр
- Хийжүүлсэн ундаа
- Чихэрлэг ундаа
- Шоколад
- Жигнэмэг
- Бялуу
- Түргэн хоол
- Бэлэн гоймон
- Чипс
- Хиам, зайдас
- Давсалсан нөөшилсэн хүнс

facebook | twitter | youtube



Б. Хоолны цэстэй танилцаарай. Хоолны цэсээс 1 ба 2 дугаар хоолыг ямар сонголттой захиалж болох талаар ярилцаарай.

ОРГИЛ ЗООГ "МЕНЮ"

ОРГИЛ НЭРИЙН ХООЛ

1. Шарсан хавцрга, ногоотой шөл, гахайн шарсан мах <i>/хачир нийслэл салат, бугаа, шимс ногооны салат /</i>	6000Т
--	-------

1-Р ХООЛ

1. Хавцргатай ногоотой шөл	4500Т	6. Бантан	4000Т
2. Банштай ногоотой шөл	4500Т	7. Банштай шөл	4500Т
3. Гурилтай шөл	4000Т	8. Банштай цай	4000Т
4. Жүнзтэй ногоотой шөл	4000Т	9. Кимчтэй шөл /хачиртай /	5000Т
5. Бинтэй хар шөл	4500Т	10. Хуйцаа /мантуутай /	4500Т

2-Р ХООЛ

1. Цүйван	4500Т	9. Шарсан хавцрга	5000Т
2. Гуляш	4500Т	10. Гахайн шарсан мах	5000Т
3. Пүнтүүзтэй хуурга	4500Т	11. Бчфштекс	4500Т
4. Тахианы шарсан гуя	4500Т	12. Бөөрөнхий мах/соустай /	4500Т
5. Өндөгтэй хуурга	5000Т	13. Нарийн махан хуурга	4500Т
6. Чинжүүтэй хуурга	4500Т	14. Хачиртай банш	4500Т
7. Шарсан төмстэй хуурга	5000Т	15. Чанасан мах /хачиртай /	8000Т
8. Агууны шарсан мах	5000Т		

Манайхаар үйлчлүүлсэн таньд баярлалаа



В. Болд 12000 төгрөгтэй. Түүнд хоол авахад нь туслаарай. Ярилцаарай.



Жишээ нь:

Нэгдүгээр хоолонд хавцргатай ногоотой шөл 4500төг
Хоёрдугаар хоолонд нарийн махан хуурга 4500төг

Г. Хэрэв чамд 10000 төгрөг байгаа бол зоогийн газрын хоолны цэсээс ямар ямар хоол сонгож захиалах байсан бэ? Бичээрэй.

Д. Үгсийг ашиглан холбоо үг үүсгэж, өгүүлбэр зохион бичээрэй.

Ж: Гурилтай шөл



Е. Нөхцөлийг зөв залгаж бичээрэй. Яаж бичсэнээ ярилцаарай.

Би
Аав
Талхыг
Бид



- тай шөл идэх дууртай.
- ын үйлдвэрт ажилладаг.
- аар хийдэг.
- ыг хүнсэндээ хэрэглэдэг.

Ажил

+

- ЫГ
- ЫН
- аас
- аар
- тай

=

Blank grid for writing the result of the word combination exercise.

Ё. Зөв дуудаж сураарай. Үгсийн утгын ялгааг ойлгон өгүүлбэрийг гүйцээж бичээрэй.

хоол



гараар бэлдсэн
идэх юм

Ээжийн хийсэн амттай.

хол



ойрын эсрэг утга

Манай гэр сургуулиас

Дасгал 5



А. Уншаад, асуултад хариулж бичээрэй.

Дотны хүмүүстээ Монголынхоо Хаан жимс чацарганаар бэлэг барья!

Монголын чацаргана №1 бэлэг

Хаан жимсний ид шид
В1, В2, В3, В4, В5, В6, В9, С, А, Е, К аминдэмүүд болон 190 төрлийн биед хэрэгтэй шим тэжээл.

Цангавал хүйтнээр, бие өвдвөл халуунаар уугаарай!

Асуулт

- Чацаргана ямар ашиг тустай вэ?
- Чацаргана ямар амттай вэ?
- Чацарганыг юу юунд хэрэглэдэг вэ?
- Чацаргана ямар ямар аминдэм агуулсан жимс вэ?



Б. Зөв харгалзуулаарай.

Зорилго
Зорилго бичих

Сэтгэл хөдлөл

Дүрслэл

Үйлдэл

Дотны хүмүүстээ Монгол орны Хаан жимс чацарганаар бэлэг барья!

Цангавал хүйтнээр, бие өвдвөл халуунаар уугаарай!

Хаан жимсний ид шидийг мэдэх үү?

Тэднийхээ эрүүл жаргалтай харцыг хармаар байна уу?



В. Зургийг ажиглаад ярилцаарай.



Асыл бэххүүндэг ааруул
Шүдний эрүүлжүүндэг ааруул
Кальцийн нөөцөг ааруул



Г. Уншаад ярилцаарай.



Ааруул идэх таван шалтгаан

1. Эрүүл шүдтэй, өндөр нуруутай болно.
2. Биеийн эсэргүүцлийг сайжруулан, дархлааг дэмжинэ.
3. Биеийн илүүдэл жингээс сэргийлнэ.
4. Чихрийн шижин өвчнөөс сэргийлнэ.
5. Биеийн эрч хүчийг нэмэгдүүлнэ.



Д. Залгаврыг зөв залгаж бичээрэй.

өвчин + өөс =

ажил + ыг =

бүжиг + ээс =

жуулчин + ыг =

амин + ы =

морин+ы =

охин + оос =

сонин+ оос =



Ё. Зөв дуудаж сураарай. Үгсийн утгын ялгааг ойлгон, өгүүлбэрийг гүйцээж бичээрэй.

хуурга



хуурай хоол

Би ээждээ хийхэд туслав.

хурга



хонины үр төл

..... бол өхөөрдөм хөөрхөн төл мал юм.



зэрлэг амьтан



гэрийн тэжээмэл амьтан



ирвэс



шилмүүс



үлэг гүрвэл



араг яс



ширэнгэн ой



тарвага



бөхөн



хурц шүд



эмгэн хумс



аймшигтай



хандгай



мөр



нүх



хадран загас



үнэрлэх



хурдлах



модны хонгил



ёл



А. Харилцан яриаг уншаарай.



Ээж ээ! Би айгаад байна.

Чи жаахан хүүхэд биш шүү дээ? Энэ бол зөвхөн араг яс.

Араг яс ч гэсэн би айж байна. Тэр маш том юм.

Энэ бол тиранозавр. Энэ амьтад одоо дэлхий дээр байхгүй болсон. Тиранозавр махан идэштэн үлэг гүрвэл.

Ээж ээ, зурагтаар үзсэн үлэг гүрвэл өвс иддэг байсан.

Үлэг гүрвэлүүд махан идэштэн, өвсөн идэштэн янз бүр байдаг.

Тэгвэл өвсөн идэштэн үлэг гүрвэлийг юу гэж нэрлэдэг бол?

Өвсөн идэштэн үлэг гүрвэлийг бронтозавр гэдэг.

Мэдэж авлаа. Ангийнхандаа үлэг гүрвэлийн музейн тухай ярьж өгнө өө.

Мөн Өмнөговь аймгаас олдсон үлэг гүрвэлийн араг ясыг дуурайн сонгож хийсэн дуугардаг, хөдөлдөг 18 төрлийн үлэг гүрвэлийн баримал бүхий “Үндэсний соёл амралтын хүрээлэн” 2016 оны 6-сарын 1-ний өдөр Өмнөговь аймагт байгуулагдсан.



Б. Уншаад асуулт зохиож бичээрэй.

Асуулт	Хариулт
.....?	Энэ бол үлэг гүрвэлийн араг яс.
.....?	Энэ амьтад дэлхий дээр байхгүй болсон.
.....?	Өвсөн тэжээлтэй үлэг гүрвэлийг бронтозавр гэдэг.
.....?	Тийм ээ би зурагтаар үлэг гүрвэл үзэж харж байсан.



В. Доорх үгсийг ашиглаад үлэг гүрвэлийн тухай ярилцаарай.

Ашиглах үгс: Ширэнгэн ойд, усанд, том биетэй, янз бүр, том, жижиг, аймшигтай, хурц шүдтэй.

Дасгал 2




А. Зурагт таницуулгыг уншаад, тоон мэдээллүүдийг тэмдэглээрэй.

Үлэг гүрвэлийн ертөнцийн хамгийн хамгийн

Үлэг гүрвэлүүд хоёр зуун дөчөөд сая жилийн тэртээ үүсэж, жаран зургаан сая жилийн өмнө мөхсөн билээ. Эрдэмтэд одоогоор таван зуу гаруй төрлийн мянгаад зүйлийн үлэг гүрвэл амьдарч байсныг тогтоогоод байна.

Хамгийн хүнд



80 тонн жинтэй сарвуут гүрвэл нь Африкийн 17 заан нийлүүлсэнтэй тэнцэнэ. Ойролцоогоор 16 метр, өндөр, 26 орчим метр урт байжээ.

Хамгийн хурдан



Тэмээн хяруулын дээд өвөг болох үлэг гүрвэлүүд дундаж хурд 60 км/цаг байсан гэж эрдэмтэд үздэг.

Хамгийн өндөр



Хамгийн өндөр үлэг гүрвэлүүдийн урд хоёр мөч арын хоёроос нь урт байсан дундаж өндөр 18.5 метр байв.

Хамгийн урт



Энэ үлэг гүрвэл нь том оврын таван автобустай тэнцэх, 40 гаруй метр урт сүрлэг амьтан юм.

Эх сурвалж: <https://www.arav.mn/>



Б. Үлэг гүрвэлийн онцлог шинжүүдийг тодорхойлохдоо юу юутай харьцуулсан бэ? Ярилцааарай.



В. Үгийн утгыг ойлгож аваарай. Цэгийн оронд нөхөж бичээрэй.

арга



юмыг хийх эв дүй

Тлоог олон бодож
бално.

араг



аргал түүх сав

..... нь эртнээс
уламжлагдаж ирсэн аргал
түүх сав юм.

Дасгал 3



А. Шүлгийг уран уншаарай.

Загас хаана унтдаг вэ?

Харанхуй болохоор загас чи

Хаана чухам унтдаг юм бэ?

Үнэгний мөрөөр явбал нүхэнд хүрнэ

Нохойн мөрөөр явбал айлд хүрнэ

Хэрэмний мөр модны хонгил руу оржээ

Хулганын мөр шалны завсар луу оржээ

Харин загас чиний мөрийг

Хайгаад хайгаад олсонгүй

Харанхуй болохоор загас чи

Хаана чухам унтдаг юм бэ?



Ж.Дашдондог



Б. Зургийг ажиглаад амьтад хаана амьдардгийг хэлээрэй.



В. Ертөнцийн гурвыг цээжлээрэй.

Урсахдаа ус хөнгөн
Хийсэхдээ өд хөнгөн
Өргөхөд өвс хөнгөн

Чулуун дээр ногоо ургуулах нэг бэрх
Усан дээр гал түлэх нэг бэрх
Үхрийн эвэр цас тогтох нэг бэрх

Дасгал 4

А. Ертөнцийн гурвыг уншаад дараах алхмуудаар дуурайн бичээрэй.

Туухад гахай нэг **хэцүү**
 Туулахад тал нэг **хэцүү**
 Тоолоход од нэг **хэцүү**



ЕРТӨНЦИЙН ГУРВЫГ ДУУРАЙН БИЧЬЕ.

АЛХАМ 1 Эхээс ойлгомжгүй үгийг ялган тэмдэглэнэ.

Жишээлбэл: туух, туулах, тоолох

АЛХАМ 2 Тэмдэглэсэн үгээ тайлбарлаж бичнэ.


Туух - амьтныг бэлчээрт гарлахаар хөдөлгөх
Туулах - аян замыг явж өнгөрөх
Тоолох - юмны хэд хэднээн болохыг мэдэх

АЛХАМ 3 Ертөнцийн гурвыг дуурайн бичнэ.

Б. Тодруулсан үгийг тохирох үгээр сольж бичээрэй.

Солих үг: бэрх, сүрхий, хүнд

В. Зургийг ажиглаад ертөнцийн гурван баяныг зохиож бичээрэй.



Г. Үгийн утгыг ойлгож, цэгийн оронд нөхөж бичээрэй.

аргал



үхрийн хатсан баас

Эзж түүлж,
цай чанав.

аргаль



зэрлэг хонь

..... нь
уулархаг нутагт амьдардаг.

Дасгал 5



А. Танилцуулгыг уншаад даалгаврыг ажиллаарай.

Ирвэс

Цоохор ирвэс дэлхийд 6500 гаруй байдаг ба нэн ховордсон амьтан. Монгол улс ирвэсийн тоогоор дэлхийд хоёрдугаарт ордог. Ирвэсийн эрийг нь гэнд, эмийг нь гинс, төлийг нь гүен гэдэг.



Ирвэс хар толботой, эрээн цоохор зүстэй. Махаар хооллодог. Ирвэс зэрлэг байгальд 15-18 хүртэл насалдаг. Ирвэс уул хаданд амьдардаг.

Биеийн урт 110-130 см, сүүлний урт 80-105 см, биеийн жин 22-55 кг орчим. Сүүлний урт биеийн урттай бараг тэнцүү.

Ирвэс Баян-Өлгий аймгийн Толбо, Бугат, Ногооннуур сумын нутагт байдаг.



Б. Уншаад асуулт зохиож бичээрэй.

Асуулт	Хариулт
.....?	Өндөр ууланд амьдардаг.
.....?	Ирвэс бол махчин амьтан.
.....?	Хүчирхэг том биетэй.



В. Хүснэгтэн мэдээллийг уншаад ирвэсийн тухай яриарай.

Амьдрах орчин	Тоо толгой	Эр, эм, төл
Өнгө зүс		Идэш тэжээл
Биеийн хэмжээ	Хэд насалдаг	Тархсан нутаг орон



Г. Үгсийн утгын ялгааг ойлгож, өгүүлбэрийг гүйцээж дэвтэртээ бичээрэй.

хад



том чулуу

Ирвэс өндөр галлоотэй авирч буурж гагдал.

хад



жимс

..... нь Салиндэл ихээр агуулдаг жимс юм.

Дасгал 6



А. Харьцуулж уншаад даалгаврыг ажиллаарай.

Жил бүрийн 3 дугаар сарын 3-нд амьтан, ургамлыг хамгаалах дэлхийн өдөр болдог. Энэ өдрийг дэлхийн олон улс оронд тэмдэглэн өнгөрүүлж төрөл бүрийн ажил зохиодог.

Агааргүй, усгүй, дуулах шувуугүй, цэцгийн анхилам үнэргүй, ан амьтадгүйгээр хүн амьдарч чадах уу?




Энэ бүхнийг байгаль хүмүүст өгдөг. Тэд биднээс төлбөр нэхдэггүй. Зөвхөн өөрсдийгөө хамгаалуулахыг л хүсдэг.



Б. Улаан номд орсон амьтадтай танилцаад, асуултын дагуу ярилцаарай.

усан булга



мазаалай



бөхөн



хар сүүлт



улаан ном



хадран загас



ирвэс



ооч ёл



хандгай




Асуулт

- Дэлхийн байгаль хамгаалах өдөр хэзээ болдог вэ?
- Яагаад дэлхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлдэг вэ?
- Улаан ном гэж юу вэ?
- Улаан номд ямар ургамал, ан амьтдыг оруулдаг вэ? Яагаад?



В. Уриалгыг уншаад асуултад хариулж бичээрэй.



*Ховордсон амьтдаа хамгаалъя!
Найзууд аа!*

Монголчууд бид хайр татам энэ амьтныг хамгаалахгүй бол өөр хэн ч үүнийг бидний өмнөөс хийхгүй. Та бүхэн чин сэтгэлээсээ дэмжихийг уриалж байна. Мазаалайг хайрлан хамгаалцгаая!

2022.04.05

5 дугаар сургуулийн Экологийн баг

Асуулт

- Хэнд хандаж уриалсан вэ?
- Юу гэж уриалсан байна вэ?
- Уриалга гаргах болсон учир юу вэ?
- Чи уриалгыг дэмжиж юу хиймээр байна вэ?



Г. Өгүүлбэрийг асуух өгүүлбэр болгон хувиргаж бичээрэй.

Жил бүрийн 3 дугаар сарын 3-нд байгалийн амьтан, ургамлыг хамгаалах дэлхийн өдөр болдог.



Д. Үгийн утгыг ойлгож, цэгийн оронд нөхөж бичээрэй.

булаг



газраас оргилох ус

Эзж ус авчирч,
цай чанав.

булга



амьтан

..... бол гоёмсол үснээсээ
балж ховордож буй амьтан юм.

Дасгал 7



А. Эхийг уншаад асуултад хариулж бичээрэй.

Гоё өдөр

Цас үргэлжлэн орсоор. Хулгана нүхэндээ унтана. Баавгай ичээндээ нойрсоно. Эмгэн хумс ясан гэртээ нойрсоно. Хэрэм модны хонгилд унтана. Тарвага газар доорх гэртээ унтана.

Тэгтэл хулганууд нүдээ нээн, ямар нэг зүйл үнэрлэв. Баавгайнууд ч бас тэр үнэрийг мэдэв. Бяцхан эмгэн хумснууд ч үнэртэж эхлэв. Модны хэрмүүд ч үнэрлэж гарав. Тарваганууд ч нүхнээсээ гарч, ямар нэг зүйлийн үнэр авав. Үнэр гарсан зүг рүү хулганууд гүйлдлээ. Баавгайнууд ч тэр зүг хурдаллаа. Эмгэн хумснууд ч гүйлдлээ. Хэрмүүд ч бас хонгилоосоо гарлаа. Тарваганууд ч нүхэн гэрээсээ гарч, гүйлдлээ.

Үнэрлээд л байлаа. Гүйлдээд л байлаа. Үнэрлээд л байлаа. Тэгснээ гэнэт зогслоо. Зогсоод л инээлдэв. Инээлдээд бүжиглэв.

Тэгээд цөмөөрөө чангаар “Тэгнэ ээ, тэр. Цасан дороос цэцэг ургажээ” хэмээн хашхиралдав.

Асуулт

- Амьтдад юу мэдрэгдсэн бэ?
- Анх ямар амьтан мэдсэн бэ?
- Хаашаа яах гэж гүйлдсэн бэ?
- Амьтад юуны учир баярласан бэ?



Рут Крауз



Б. Дараах үгсийг давтаж уншаарай. Уншихдаа үгсийг зөв дуудаж, нүдлэн тогтоогоорой.

яргуй



эмгэн хумс



тарваганы нүх



хулганы нүх



баавгайн ичээ



модны хонгил



В. Эхийн үйл явдлыг дарааллын дагуу ярилцаарай.

Эхлээд

Дараа нь

Эцэст нь



Г. Доорх хүүрнэх өгүүлбэрийг асуух өгүүлбэр болгож бичээрэй.

Цасан дороос цэцэг ургажээ.



Д. Дээрх эхээс олон тоот үгсийг түүж бичээрэй.

Жишээлбэл: хулганууд,

Дасгал 8



А. “Арслан хулгана хоёр” сургамжит өгүүллэгийг уншаарай.



Араатны хаан арслан ойд ан хийж байгаад ихэд ядарсан учир үүрэндээ ирээд унтаад өгчээ.

Тэгтэл нэг жижиг хулгана дээгүүр доогуур нь яваад унтуулсангүй гэнэ.



Арслан сэрээд хулганыг бариад авав. Уурандаа хулганыг базаж алахын даваан дээр хулгана өршөөл эрэн гуйж гэнэ:

- Намайг битгий алаач. Магадгүй нэг өдөр би чамд тус болох ч юм билүү гэв. Арслан хулганы үгийг сонсоод инээд нь хүрч:

- Чи ийм жижиг хулгана байж надад яаж тусалж чадах вэ дээ. Гэхдээ яах вэ чамайг амьд үлдээе гэв. Тэр явдлаас хойш хэсэг хугацаа өнгөрөв.



Харин нэг өдөр арслан анчдын тавьсан торонд орчхож гэнэ. Хэчнээн үсэрч цовхроод хашхирсан ч торноос гарч чадсангүй.

Харин тэгтэл нөгөө амийг нь өршөөсөн хулгана тэр хавиар явж байгаад хөөрхий байдалд орсон арсланг олж харав. Тэгээд шууд л торыг шүдээрээ хазсаар байгаад арсланг торноос чөлөөлөв.



Хулгана арсланд хандан:

- Чи намайг жижиг гэж голж байсан. Харж байгаа биз дээ. Би амийг чинь аварч чадлаа шүү дээ гэв. Арслан үүнээс хойш ямар ч жижиг амьтанд тус байдаг юм байна гэдэгт итгэжээ.



Б. Асуултын дагуу зөв харгалзуулан яриарай.

Арслан юу хийж байсан бэ?	Анчдын тавьсан торонд орчихсон.
Арсланг хэн унтуулаагүй вэ?	Сэрээд хулганыг барьж авсан.
Арслан яасан бэ?	Хулганыг тавьж явуулсан.
Хулгана арслангаас юу гэж асуусан бэ?	Анчдын торыг мэрж, арсланг аварсан.
Арслан ямар шийдвэр гаргасан бэ?	Арсланд дараа нэг өдөр тус болохыг амласан.
Нэгэн өдөр арсланд юу тохиолдсон бэ?	Унтаж байсан.
Хулгана юу хийсэн бэ?	Хулгана амлалтаа биелүүлсэн.
Хулгана амласнаа биелүүлсэн үү?	Хулгана .



В. Номын тэмдэглэлийг уншаад эхлэл, гол, төгсгөл хэсгээр зааглан бичээрэй.

Би уншсан номынхоо талаар тэмдэглэл хөтөлдөг. Би 2022 оны 4-р сарын 23-нд “Арслан хулгана хоёр” үлгэрийг уншиж дууссан. Номын зохиолч нь Л.Н.Толстой. Номын гол баатар нь арслан хулгана хоёр юм. Надад хулганы хэлсэндээ хүрсэн нь таалагдсан. Жижиг ч бай том ч бай ямар нэг тус буцаж ирдэг гэдгийг энэ үлгэрээс мэдэж авлаа.

Санамж:

- Бичихийн өмнө зохиолоо уншиж судлах
- Асуултын дагуу бичих зүйлээ сонгоно.
- Асуултын дагуу товч тодорхой бичнэ



Г. 18-р талын номын тэмдэглэл бичих загварыг ашиглан “Арслан хулгана хоёр” үлгэрийн тэмдэглэлийг бичээрэй.

Дасгал 9



А. Үйл явдлыг зөв дараалалд оруулан бичээрэй.

- Намайг битгий алаач нэг өдөр чамд тус болох ч юм билүү?
- Торыг шүдээрээ хазсаар байгаад арсланг торноос чөлөөлсөн.
- Арслан хулганыг барьж авсан.
- Чи надад яаж туслах вэ? Гэхдээ чамайг амьд үлдээе.
- Арсланд хулгана дараа нь тус болохыг амласан.
- Анчдын торыг мэргэ арсланг аварсан.
- Үйл явдал ойд өрнөсөн.
- Жижиг ч бай том ч бай ямар нэгэн тус буцаж ирдэг.




Б. Ертөнцийн гурвыг уншаад дуурайж бичээрэй.

Эрдэм ном дээд баян
Үр хүүхэд дунд баян
Эд хөрөнгө адаг баян


Үйлэнд уран гайхамшиг
Үгэнд цэцэн гайхамшиг
Дайнд баатар гайхамшиг



В. Тодруулсан үгийг тоон дараалал болон биеийн хэсэгтэй адилтган үг холбож дэвтэртээ бичээрэй.



Г. Холбоо үг үүсгээд, өгүүлбэр зохиож бичээрэй.



Д. Үгсийг зөв байрлуулж, зүйр цэцэн үг бүтээгээрэй.

мэдэхэд, Уншиж, сайхан, ном

ярихад, Уулзаж, найз, сайхан

БАЙГАЛЬ ДЭЛХИЙ

Зуралт толь



хүрхрээ



хөшөө



хадны сүг зураг



мөсөн гол



цэнгэг



рашаан



сүүн гол



цасан оргил




арц



зүлэг



ширгэх



тулалдах



морьт хөшөө



торх



баганат хөшөө



аялах



ан хийх



үзэсгэлэнтэй



хөх тэнгэр



ус



А. Түүх дурсгалт газруудын талаар уншиж танилцаарай.



Төв аймгийн Эрдэнэ сумын “Цонжин болдог” хэмээх газарт Чингис хааны морьт хөшөө бий.



Хасбаатар, Байкалов нарын удирдсан цэргүүд цагаан оросын цэрэгтэй тулалдсан түүхэн үйл явдал болсон Толбо нуур.



Бага Ойгор, Цагаан салаагийн хадны сүг зураг.



36 метр өндөр эгц хаднаас буух Бага Түргэний хүрхрээ.



Монгол Улсын баатар М. Икейн Халх голын баруун эрэг дээр байдаг баганат хөшөө.



Хан Хэнтийн дархан цаазат газарт “Мэлхий хад” хэмээх байгалийн нэн сонин тогтоцтой өндөр хад бий.



Б. Харилцан яриаг төлөөлөн уншаарай.



Би зуны амралтаараа уулаар зугаалмаар байна.

Сайхан санаа байна. Энэ жил Алтай Таван Богдод очиж Цагаан Салаагийн хадны сүг зурагтай танилцъя.



Би Таван Богд руу явмааргүй байна. Бага түргэний хүрхрээ рүү явъя.

Хүүхдүүд ээ! хаана очихоо гэр бүлээрээ ярилцъя.

Бага түргэний хүрхрээ ч гоё газар. Гэхдээ Цагаан Салаагийн хадны сүг зурагтай танилцвал илүү сонирхолтой.

Хадны сүг зураг гэж юу вэ?



Эрт цагийн хүмүүсийн үлдээсэн зурган захиа.

Зурган захиа гэж юу вэ?



Хаданд олон төрлийн амьтад, морь унасан хүмүүс, ан хийж буй анчид, байлдаж буй цэргүүд гэх мэт олон зүйлийг зурсан байдаг.

Монгол орныхоо түүх дурсгалт газраар жил бүр аялъя.



Тэгвэл ирэх жил Бага Түргэний хүрхрээ явъя.



В. Уншаад асуулт зохиож бичээрэй.

Асуулт	Хариулт
.....?	Цагаан салаагийн хадны сүг зургийг очиж үзэхээр болсон.
.....?	Хадны зургийг найман мянган жил үргэлжлүүлэн зурсан.
.....?	Хадны зургийн өргөн нь 500 метр, урт нь 15 километр юм.
.....?	Хаданд ан амьтад, хүмүүсийн аж амьдралыг харуулсан зураг байдаг.



Г. Дараах зургийг ажиглаарай. Монгол орныхоо түүх дурсгалт газар болох Таван Богд, Толбо нуурын талаар 3-4 бүтэн өгүүлбэрээр танилцуулж бичээрэй.



Ашиглах үгс:

Сүүн гол, Монголын хамгийн өндөр уул, Найрамдал оргил, 4374м, аялал, Потанины мөсөн гол, Алтай Таван Богд

Хасбаатар, Байкалов, цэргүүд, тулалдсан, түүхэн үйл явдал, Толбо нуур,




Д. Хадны сүг зурагт юу юуг дүрсэлсэн байна вэ? Яриарай.



Е. Үгийн утгыг ойлгож аваарай. Цэгийн оронд нөхөж бичээрэй.

ТҮҮХ



түүх шашдир

Миний ах Жаргал судалдаг.

ТҮҮХ



жимс, ногоо түүх

Хүүрсдүүд жимс дуртай.

Дасгал 2



А. Сурталчилгааг уншаад, юугаар хүргэж болохыг ярилцаарай.

Та хамгийн сүүлд хаашаа аялсан бэ? Байгалийн үзэсгэлэнг биширч, дөрвөн улирлыг нэг доор хармаар байна уу? Тэгвэл Алтай Таван Богд уул руу аялахыг санал болгож байна. Яагаад гэвэл, жилийн дөрвөн улирал нэг дор хослон оршдог. Үгээр хэлж зүйрлэмгүй сайхан байгальтай.

Баян-Өлгий аймгийн байгалийн гайхалтай тогтоц бүхий Сүүн гол, Потанины мөсөн гол, Монголын хамгийн өндөр уул болох Алтай Таван Богдын Найрамдал оргилыг, Хурган, Хотон, Номин нуур, Их бага Түргэний хүрхрээ гээд аяллын турш үзэх, бишрэх зүйл маш ихтэй.

Хосгүй байгальтай Алтай Таван Богд руу аялахыг урьж байна.





Б. Сурталчилгааны бүтэцтэй танилцаарай.

Зорилго

Байгалийн үзэсгэлэнг биширч, дөрвөн улирлыг нэг доор хармаар байна уу?

Сэтгэл хөдлөл

Энэ жилийн аяллаа төлөвлөж амжаагүй бол Алтай Таван Богд уул руу аяллыг санал болгож байна.

Дүрслэл

Жилийн дөрвөн улирал нэг дор хослон оршдог. Үгээр хэлж зүйрлэмгүй сайхан байгальтай.

Үйлдэл

Хосгүй байгальтай Алтай Таван Богд руу аялахыг урьж байна.

Алтай Таван Богд



Потанины мөсөн гол



Хотон нуур



Хурган нуур



В. Цагаан салаагийн хадны сүг зургийг очиж үзэхэд зориулсан сурталчилгаа бичээрэй. Сурталчилгааг бичихдээ хүснэгт ашиглаарай.

Ашиглах үгс: Цагаан салааны хадны зураг, урт нь 15км, өргөн нь 500м, амьтад, морь унасан хүмүүс, ан хийж буй анчид, байлдаж буй цэргүүд, аялахыг хүсэх, 8000 жилийн өмнөх зурган захиаг үзэх

Зорилго:

Сэтгэл хөдлөл:

Дүрслэл:

Үйлдэл:



Г. Өгүүлбэрийг дэвтэртээ хуулж цэвэр, сайхан бичээрэй.

Монголын хамгийн өндөр уул бол Алтай Таван Богд юм.

Хамгийн том мөсөн гол: Потанины мөсөн гол.

Хамгийн том загас: Тул

Хамгийн том шувуу: Тас

Дасгал 3



А. Шүлгийг уран уншаарай.

Миний нутаг

Хөх сайхан тэнгэртэй

Үнэр сайхан өвстэй

Хөвч сайхан модтой

Өнгийн сайхан цэцэгтэй

Тунгалаг сайхан агаартай

Хадтай сайхан уултай

Тунамал сайхан устай

Хан бүргэд сайхан шувуутай

Алтан наран туяа мандмал

Арын сайхан рашаан ундармал

Мөнгөн саран туяа гиймэл

Арцын сайхан үнэр анхилмал

Мөнх сайхан нутаг минь

Мөнх сайхан нутаг минь

Монголын сайхан орон!

Монголын сайхан орон!

Бямбын Ринчен

Асуулт

- Монгол орныг ямар тэнгэртэй гэж дүрсэлсэн бэ? Яагаад?
- Монгол орныг ямар агаартай гэж дүрсэлсэн бэ? Яагаад?
- Монгол орныг ямар устай гэж дүрсэлсэн бэ? Яагаад?



Б. Дараах өгүүлбэрүүдийн ард тохирох тэмдгийг тавьж, ямар өгүүлбэр болохыг тодорхойлж бичээрэй.

Яндаж болдоггүй далай шил

Яасан баян нутаг вэ ○

Чи үүнийг хурдан гүйцэтгэ ○

Та номоо авахаа мартуузай ○

Урьхан салхи сэвэлзэнэ ○



В. Үгсийн утгын ялгааг ойлгон зөв дуудаж уншаарай. Өгүүлбэрийг бичээрэй.

аарц



цагаан идээ

Тарал, айргийг буцалган шар сур нь шүрсэн цагаал гэнэ.

арц



ургамал

Өндөр ууланд ургах мөнх ногоон, анхилуун үнэртэй ургамлыг гэнэ.

Дасгал 4



А. Эхийг уншаад даалгаврыг ажиллаарай.

Монгол оронд нэгэн үзэсгэлэнт нуур байв. Нуур нь цэнгэг устай, загас ихтэй билээ. Нуурын үзэсгэлэнг сонирхох гэж хүмүүс ирдэг байв. Хүмүүсийн нэг хэсэг нь нуурын усанд сэлнэ. Нөгөө хэсэг нь загас агнана. Бүгд үзэсгэлэнг гайхан нуурын эргээр зугаална.

Хүмүүс нуурын эргээр их хэмжээний хог хаясан байжээ. Нуур хүмүүст гомдож, ус нь ширгэж загасгүй болов. Нуурын үзэсгэлэнг үзэхээр ирсэн хүмүүс загас ч үгүй, ус ч үгүй болсонд гайхаж нуураас учрыг нь асуухад:

- Хүмүүсийн үлдээсэн хогноос болж, цэнгэг ус минь ширгэж, загасгүй болж гоо үзэсгэлэнгээ алдлаа хэмээн гуниглан хариулжээ.



Б. Зөв хариултыг олоод дэлгэрүүлэн бичээрэй.

Нуур яагаад хүмүүст гомдсон бэ?

1. Хүмүүс нуурыг хайрладаг болохоор

2. Хүмүүс загас агнадаг болохоор

3. Хүмүүс нуурт сэлдэг болохоор

4. Хүмүүс нуурт хог хаясан болохоор

ГОМДСОН




В. Зургийг ажиглаад сайн үйлийг 2-3 өгүүлбэрээр бичээрэй.









Г. Хүн усыг юу юнд ашигладаг вэ? Ярилцаарай.



Д. Зургийг зөв дараалалд оруулж үйл явдалд тохирох өгүүлбэр зохиож бичээрэй.



Е. Нуурын хэлсэн үгийг төлөөлөн уншаарай.



Ё. Үгийн утгыг ойлгож аваарай. Цэгийн оронд нөхөж бичээрэй.

ширэг



зүлэг ногоо

*Би зун болохоор зуслангийнхаа
..... байнга усалдаг.*

ширгэ



ууршиж алга болох

*Тал усанд хог хаявал
.....*

Дасгал 5



А. Зурагт мэдээллийг уншаад асуултад хариулж, ярилцаарай.

Дэлхийн бүх усыг **100 торх** гэж бодвол
үүний **97 торх** нь далайн давстай ус,

2 торх нь цэвэр ус,

1 торх нь гүний ус юм.

Асуулт

- Далайн давстай усыг өдөр тутмын амьдралд ашиглаж болох уу?
- Танайх өдөрт хэдэн литр цэвэр ус ашигладаг вэ?
- Усыг зөв ашиглахын тулд чи юу хийж чадах вэ?



Б. Зургуудийг ажиглаад ярилцаарай.



В. Усаа хайрлахад уриалсан уриалга бичээрэй.

Ашиглах үгс: Амьдралыг тэтгэгч, бохирдуулахгүй, хэмнэх, үхэж үрэгдэх, усны хомсдол, гамтай зарцуулах, хамгаалъя, хайрлая, амьдрал байхгүй



Г. Үгсийн утгын ялгааг ойлгон зөв дуудаж уншаарай. Өгүүлбэр бичээрэй.

торх

модон сав

Шингэн зүйл агуулах модон савыг чэнэ.

торох

тээглэх

Заллихаг хоолойд юм тээглэхийг чэнэ.

Дасгал 6



А. Шүлгийг уншаад асуултад хариулж бичээрэй.

Агаар

Ангиараа бид
Агаарын тухай

Мундаг ширүүн
Маргалдаж гарлаа

Гарт юу ч баригдахгүй
Ганц юм ч үзэгдэхгүй

Агаар ер нь
Алга гэж би хэллээ
Араас нэг нь
Ам таглалаа



Багтрах шахахдаа би
Байна, байна гэж хашгирав.

Эх сурвалж: www.maamuu.mn

Асуулт

- Хүүхдүүдийн маргалдсан шалтгаан юу вэ?
- Хүү яагаад “Агаар алга” гэж хэлсэн бэ?
- Харин ямар учраас “Агаар байна” гэж зөвшөөрөв?



Б. Төгсгөл эхлэлийг холбон үгийн хэлхээ үүсгэж уншаарай.

агаа → р ашаа н



В. Эсрэг утгатай үгсийг олж, утгыг тайлбарлаад дэвтэртээ хуулж бичээрэй.

хүнд
бараан
өргөн
толботой



хөнгөн
цайвар
нарийн
толбогүй



Г. Тааврыг таагаад дэвтэртээ хуулж бичээрэй.

- Би амтгүй
- Би өнгөгүй
- Би үнэргүй
- Би хэлбэргүй
Гэхдээ надгүй бол
амьдрал үгүй.




- Би 4 хөлтэй
- Би том биетэй
- Би урт хамартай
- Би том чихтэй



ХУВЦАСЛАЛТ, ХУВИЙН СОЁЛ

Зурагт толь



ТОМ ЖИЖИГ



хүнд хөнгөн



урт богино



өндөр нам



өргөн нарийн



баруу хэлхгэр



бараан цайвар




гоёмсог энгийн



толботой



уранхай




ТОВЧ



цахилгаан товч




оёх



уртасгах



хасах



богиносгох



өөдрөг



хөгжилтэй



тайван




ичимхий



гунигтай



ганцаардмал



ихэмсэг



дээрэлхүү



А. Уншаад гэр бүлийнхний өмссөн хувцсыг ангилан бичээрэй.

Аав нь саарал ноосон цамц, хөх жинстэй, хар ботинктой байна. Нарны шил зүүж, гартаа жижиг хар цүнх барьжээ.

Ээж нь дэрвэгэр хормойтой шар эрээн дашинз, цагаан сандаал, бүрх малгай өмсжээ. Хүзүүндээ шар алчуур зангидаж, гартаа шүхэр барьсан байна.

Хүү нь хөх богино ханцуйтай цамц, улаан шорт, шар пүүзтэй байна. Саравчтай малгай өмсөж үүргэвч үүрчээ.

	Хувцас	Гутал	Туслах хэрэгсэл
Аав
Ээж
Хүү



Б. Харилцан яриаг хосоор уншаад асуултад хариулж бичээрэй.

Сайн байна уу? Манай дэлгүүрт тавтай морил. Танд юугаар туслах вэ?



Би малгайтай ноосон цамц бас усны гутал хайж байна.

Та гутал, хувцас ямар хэмжээтэйг өмсдөг вэ? Өнөөдөр манай дэлгүүрийн бараа 30 хувь хямдарсан байна.

Өө, ямар сайн юм бэ. Би цамц дунд хэмжээтэйг, гутал 37 өмсдөг.

Энэ цамц дунд хэмжээтэй, энэ гутал 37, өмсөөд үзээрэй.

Цамц ямар ямар өнгө байгаа вэ? Усны гутал арай урт түрийтэй байгаа юу?

Хар, саарал, цагаан өнгө байгаа. Хувцас солих өрөөнүүд тэнд байгаа.

Танд таарч байна уу?

Баярлалаа. Би хар бас саарлыг өмсөж үзье.

Байгаа. Үүнийг өмсөөд үз дээ.

Таарч байна. Саарлыг авъя. Бас усны гутал урт түрийтэйг авъя.

Цамц 40000, гутал 58000 төгрөг. Үүнээс 30 хувь хямдарна. Та бэлнээр төлөх үү? Картаар төлөх үү?

Бэлнээр төлнө.

Баярлалаа. Та дахин ирж үйлчлүүлээрэй!

Баярлалаа, баяртай.

Асуулт

- Хүү хайж очсон хувцсаа авч чадсан уу?
- Хүү ямар хэмжээтэй, ямар өнгөтэй цамц авсан бэ?
- Хүү ямар усны гутал авсан бэ?
- Худалдагч түүнд ямар хэмжээтэй цамц санал болгосон бэ? Түүнийг авсан уу? Яагаад?
- Бат нийт хэдэн төгрөгийн бараа авсан бэ?



В. Зургийн дагуу түлхүүр үгсийг ашиглан тоочин танилцуулж яриарай.



Г. Онъсогыг таагаад цээжлээрэй.

Айл нэгтийн ам нэг
Ам нэгтийн хөл хоёр



Хүн гэхэд хүзүүгүй
Хөхүүр гэхэд ёроолгүй



Дасгал 2



А. Цэгийн оронд тохирох үгсийг нөхөж дэвтэртээ бичээрэй.



Жишээ: Бат улаан цамц, богино хөх өмдтэй байна.

Болд ногоон шар....., улаан байна.

Эгшиглэн цагаан, ногоон байна.

Билгүүн цэнхэр....., хар байна.


Ану улбар шар ногоон, хөх байна.

Сүхээ нил ягаан ногоон, улаан байна.

Туяа шар, цэнхэр байна.



Б. Зургийг ашиглан биеийнхээ хэмжээг авч дэвтэртээ тэмдэглээрэй.



1. Өндөр
2. Цээжний тойрог
3. Бүсэлхийн тойрог
4. Өгзөгний тойрог

















В. Өөрийн хувцасны хэмжээг тодорхойлъё.



Г. Хөлийн хэмжээг авч гутлын хэмжээгээ тодорхойлоорой.

Дасгал 3

А. Шошгуудыг харьцуулан уншаарай. Ямар ямар мэдээлэл авав? Бичээрэй.

 <p>○</p>  <p>Хэмжээ: S M L XL</p> <p>Өнгө: </p> <p>Үнэ: 99,000</p> <p>Хямдрал: 30%</p> <p>Хямдарсан үнэ: 69,300</p> <p>www.little-steppe.com www.vandesteppe.com</p>	  <p>P ХУУРАЙ, ХИМИ ЦЭВЭРЛЭГЭЭ</p> <p> ГАРААР УГААНА</p> <p> ХӨНДЛӨН ГАДАРГУУ ДЭЭР ХАТААНА</p> <p> БАГА ХЭМЭЭР ИНДҮҮДНЭ</p> <p> УГААЛГЫН МАШИНД СЭГСРЭХГҮЙ</p> <p> ЦАЙРУУЛАГЧ АШИГЛАХГҮЙ</p> <p> МУШГИЖ БОЛОХГҮЙ</p> <p>www.little-steppe.com www.vandesteppe.com</p>	<p>TIMBERLAND</p> <p>ЭРЭГТЭЙ 6" ДЭЭД ЗЭРГИЙН ШИР</p> <p>ХЭМЖЭЭ</p> <p>ЕВРОП 43.5 АЗИ 27.5 АМЕРИК 9</p>    <p>9 789919 004804</p>
--	--	--

Б. Шошгын загварыг ажиглан өгүүлбэрээр тоочин бичээрэй.

УГААХ ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ТАЙЛБАР



В. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж өгүүлбэрийг төгсгөж бичээрэй.

Нөхөх үг: болно, болохгүй

- Хөвөн даавуун хувцсыг индүүдэж
- Үслэг эдлэлийг хими цэвэрлэгээнд өгч
- Ноолууран хувцсыг угаалгын машинд угааж
- Борооны цувыг индүүдэж
- Цагаан хэрэглэл угаахад цайруулагч ашиглаж
- Ноосон хувцсыг халуун усаар угааж
- Илгэн гутлыг тосолж
- Жинсэн хувцсыг угаалгын машинд угааж.....

Д. Үгийн утгыг ялгасан өгүүлбэр зохион бичээрэй.


ШОГОЛ



ном судрын хайрцаг

Ах модон судраа хадгалдаг.

ШОГЛО



өдөх, шоолох

Хэн нэгнийг нь муу үйлдэл юм.

Дасгал 4



А. Шүлгийг II тэмдэг ашиглан зогсолт хийж, уран уншаарай.

Монгол дээл

Ээжийн оёсон шинэхэн дээл
 Эвсээрхэн хөнгөхөн хөөрхөн дээл
 Тоног эмжээр нь зохисон дээл
 Товч шилбэ нь тохирсон дээл
 Тоос шороон дээр хөрвөөгүй дээл
 Тос өөхөнд шүргэмгүй дээл
 Хийсэн эд нь хиргүй байг
 Хийлгэсэн эзэн нь хийморьлог яваг гэж
 Ачит ээжийн минь ерөөсөн дээл
 Айлын эгчээр мялаалгасан дээл


Т.Жамьянсүрэн



Б. Шүлгийг дэвтэртээ цэвэр сайхан хуулж бичихдээ зогсолт хийх газарт тэмдэг тавиарай. Үлгэрлэвэл: Ээжийн оёсон II шинэхэн дээл



В. Холбоо үг болгон дэвтэртээ бичээрэй.



Г. Дээлийн бүрдэл хэсгийг нэрлээд хаана байдгийг тайлбарлан бичээрэй.

Үлгэрлэвэл:

ТОВЧ

- дээлийн зах, энгэр, суга, ташаанд байна.



Д. Үгийн утгыг ялгасан өгүүлбэр зохион бичээрэй.


дээл



хувцас

Бид наадмаар
 өмсөж гоёдог.

дэл



адууны хүзүүн
 дээрх үс

Аав моринхоо
 заслаа.

Дасгал 5



А. Эхийг уншаад үйл явдал хаана, хэзээ өрнөж буйг бичээрэй.

Гоёлын дашинз

Туяа охинд төрсөн өдрийн урилга иржээ. Түүний найз Заяа урилга илгээсэн байв. Туяа:

- Ээж ээ, би ямар дашинз өмсөх вэ? Ээж нь:

- Ээж нь гоёлын дашинз оёж өгье. Туяа:

- Ээж ээ, би мэргэн санаа оллоо. Энэ энгийн ягаан дашинзыг хоёулаа гоёод чимчихье. Ингээд тэд дашинзны хормойд дэрвэгэр тууз залган, шар эмжээр оёв. Захыг нь бас шараар эмжиж энгэрт нь гоёмсог товчнууд хадлаа. Ханцуйг нь бөмбийлгөж, шар тууз ард нь зангидав. Яг л гүнжийн дашинз болох нь тэр ээ. Туяа маш их баярлаж ээжийгээ тэвэрч үнслээ.



Б. Даашинзнуудыг дүрслэн бичээрэй. Аль нь Туяа охины дашинз вэ?



В. Эхийн үйл явдлыг дараах загвараар яриарай.



Г. Урилгыг уншаад асуултад хариулж бичээрэй.

Хэнийг урив?
Юунд урив?
Хэзээ болох вэ?
Хаана болох вэ?
Хэн урив?



Д. Төрсөн өдөр болох газрыг төсөөлөн дэвтэртээ зураарай.



Е. Урилгын загвар бүтцийг ашиглан өөрийн төрсөн өдрийн урилгыг бүтээгээрэй.

Дасгал 6



А. Дараах үгсээс тохирохыг нөхөж, өгүүлбэр бүтээж бичээрэй.

Нөхөх үгс: бүсэлдэг, өмсдөг, барьдаг, тайлдаг, зүүдэг, сольдог, үүрдэг

1. Би хүйтэн салхитай өдөр ороолт
2. Би нартай өдөр нарны малгайгаа
3. Би биеийн тамирын хичээлд орохдоо хувцсаа
4. Би халууцвал гадуур хувцсаа
5. Би хүйтэн өдөр дулаан хувцсаа давхарлаж
6. Би хичээлд явахдаа цүнхээ
7. Би бороотой өдөр шүхэр
8. Би дээл өмсөхдөө бүс

Асуулт

- Чиний хамгийн дуртай хувцас юу вэ?
- Хувцсаа хэрхэн сонгож өмсдөг вэ?
- Чи сургуулийн дүрэмт хувцас өмсдөг үү?
- Чи төрсөн өдөрт явахдаа юу өмсдөг вэ?
- Чи спортоор хичээллэхдээ юу өмсдөг вэ?



В. Үгсийг эсрэг утгаар нь харгалзуулан дэвтэртээ бичээрэй.



Г. Дэвтэртээ бэлэн хувцасны дэлгүүр зураарай. Хаана юу байрлуулахаа нарийн тооцоолоорой.



Д. Зургаа тайлбарлаж яриарай.



А. Шүлгийг уншаарай.

Ээжийн сургаал

Найрсаг хөөрхөн ааштай байвал
 Найзууд олонтой байдаг гэсэн
 Уур уцааргүй инээж явбал
 Урт удаан насалдаг гэсэн
 Хүний үгийг сонсож явбал
 Өөрт заавал тустай гэсэн
 Эрдэм ном их сурвал
 Эрхэм баян тэр гэсэн
 Ээж надад ингэж хэлсэн
 Эрхэмлэн санаж яваарай гэсэн



Т.Жамьянсүрэн

Асуулт

- Чамд ахмад хүмүүс юу юу гэж сургадаг вэ?
- Түүнийг хэрэгжүүлэхийн тулд чи юу хийдэг вэ?
- Дүү нартаа хандан чи ямар сургаал хэлэх вэ?
- Түүнийг хэрэгжүүлэхэд нь ямар зөвлөгөө өгөх вэ?



Б. Уншаад асуулт зохиож бичээрэй.

Асуулт	Хариулт
.....?	Сайхан ааштай бол олон найзтай байдаг.
.....?	Уур уцааргүй бол урт насална.
.....?	Хүний үгийг сонсож явбал өөрт тустай.



Г. Үгийн утгыг ялгасан өгүүлбэр зохион бичээрэй.

уур

сөрөг сэтгэл хөдлөл

“..... биеийг зовооно” зүйр үгийн утга юу вэ?

уур

агаарт дэгдсэн хий

Ус халаад болон дэгдэв.

Дасгал 8


А. Эерэг болон сөрөг сэтгэл хөдлөлийг ялган бичээрэй.

	СЭТГЭЛ ХӨДЛӨЛ	ЯАДАГ ВЭ?	ЮУ ХИЙХ ВЭ?
	<ul style="list-style-type: none"> ууртай ихэмсэг дээрэлхүү 	<ul style="list-style-type: none"> маргадаг эсэргүүцдэг орилж хашхирдаг 	<ul style="list-style-type: none"> Гүнзгий амьсгаа ав 10-100 хүртэл тоол Дасгал хөдөлгөөн хий Унтаж амар
	<ul style="list-style-type: none"> сандруу тэвдүү цухалдуу 	<ul style="list-style-type: none"> булзааруулдаг түгшдэг сэтгэлээр унадаг 	<ul style="list-style-type: none"> Сайхан үг хэл Тусламж хүс Булчингаа суллаж, амраа Дотно хүнтэйгээ ярилц
	<ul style="list-style-type: none"> хөгжилтэй өөдрөг өөртөө итгэлтэй 	<ul style="list-style-type: none"> инээдэг зорилготой халамжтай 	<ul style="list-style-type: none"> Бусдыг сонсож, тусал Таларх Зорилгодоо хүрэх алхам хий
	<ul style="list-style-type: none"> урамгүй гунигтай ганцаардмал 	<ul style="list-style-type: none"> зожиг унжгар зорилго тэмүүлэлгүй 	<ul style="list-style-type: none"> Тэвэр, тэврүүл Салхинд алх Хөгжим сонсох Сонирхлоо хөгжүүл

Б. Хүснэгтэн мэдээллийг уншаад юуг мэдрэхэд яадгийг тайлбарлаж бичээрэй.

Г. Үгийн утгыг ялгасан өгүүлбэр зохион бичээрэй.

атгах



гараа базах

“Чамлахаар чанга”
зүйр үгийн утга юу вэ?

адгах



сөрөг сэтгэл хөдлөл

Тлаалгүй зүйл болоход
сандраасгүй байх чухал.

Дасгал 9



А. Чи дараах мэдрэмжийг мэдрэхдээ юу хийдэг вэ? Бичээрэй.

Уурлахаараа..... Гомдохоороо

Баярлахаараа Ганцаардахаараа



Б. Бүдүүвчийг ашиглан сэтгэл хөдлөлөө хэрхэн удирддаг тухайгаа яриарай.

СЭТГЭЛ ХӨДЛӨЛӨӨ ХЭРХЭН УДИРДДАГ ВЭ?



СЭТГЭЛ ХӨДЛӨЛИЙН НЭР

- Би _____ байсан.
Жишээ: уурлаж, гуниглаж,
бухимдаж
- Надад _____ санагдсан.
(Цөөн үгээр хэлээрэй)

ШАЛТГААН НЬ ЮУ БАЙВ?

- Би _____-д байсан.
(хаана)
- Би _____ ажигласан.

СЭТГЭЛ ХӨДЛӨЛӨӨ УДИРДАХ

- Миний гаргасан _____ ааш
эргэн тойрны хүмүүст ямар
санагдсан бол?
- Би өөрийгөө хянаж чадсан
билүү?
- Хянаж чадаагүй бол яах
хэрэгтэй байсан бэ?

ТЭР ҮЕД ЯМАР ААШ ГАРГАВ?

- Би _____ мэдэрсэн.
(зан ааш, үйлдэл)
- Би уг нь _____-г
хиймээр байсан.



В. Үгсийн алдааг олж, зөв болгон үг бүтээж бичээрэй.

сэдхэл, мэдэрэмж, гуныглах, удардах, хашгирах, маргадаг, гарагдаг,
хэдрэлдэг, тайвшираад



Г. Зүйр цэцэн үгийг уншиж, утгыг ярилцаарай.

Уур биеийг зовооно

Уул морийг зовооно

Омогтой тархинд ухаан бага

Овтой тархинд ой бага

УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШИЛ

Зуралт толь



бөх барилдах



сур харвах



морь уралдах




бөхийн засуул



зодог шуудаг



түрүү магнай



баян ходоод



бариа



уяач



нум сум



бай



харваач



тоорцог



юүдэн



дээл



бүс



монгол гутал



9 цагаан туг



гараа



тэрлэг



А. Харилцан яриаг уншаад даалгаврыг ажиглаарай.



Чи ямар баярт дуртай вэ?

Яагаад?

Эрийн гурван наадам гэж юуг хэлдэг вэ?

Наадам хэзээ болдог вэ?

Эрийн гурван наадмын хамгийн сонирхолтой нь юу вэ?

Яагаад?

Би энэ жил эрийн гурван наадмыг заавал үзэх болно.

Миний дуртай баяр бол наадам.



Зуны сайхан өдрүүдэд эрийн гурван наадам үзэх үнэхээр гоё.

Морины уралдаанаар хэний морь хамгийн хурдан болохыг, үндэсний бөхийн барилдаанаар хэн хамгийн хүчтэй болохыг, сурын харваагаар хэн хамгийн мэргэн нь болохыг тодруулдаг юм.

Наадам жил бүрийн долоодугаар сарын арван нэг, арван хоёр, арван гурванд болдог.

Миний хувьд дааганы уралдаан үзэх сонирхолтой байдаг. Арван хоёр, арван гурванд болдог.

Дааганы уралдаанд хамгийн сүүлд ирсэн даага ба унаач хүүхдийг шагнадаг. Энэ даагыг баян ходоод гэж нэрлэдэг.



Б. Уншаад асуулт зохиож бичээрэй.

Асуулт	Хариулт
.....?	Наадам гурван өдөр үргэлжилдэг.
.....?	Хадны зургийг найман мянган жил үргэлжлүүлэн зурсан.
.....?	Хурдан морь унадаг хүүхдийг унаач хүүхэд гэдэг.
.....?	Энэ даагыг баян ходоод гэж нэрлэнэ.



В. Эрийн гурван наадмын тухай зураг ашиглан яриарай.



Г. Дараах үгсийг давтаж уншаарай. Уншихдаа үгсийг зөв дуудаж, тогтоогоорой.

зодог шуудаг



унаач хүүхэд



сур харваа



Д. Үгийн утгыг ялгасан өгүүлбэрийг гүйцээн бичээрэй.

бөх



барилддаг хүн

Миний ах аймгийн арслан
цалтай хүн.

бөх



тэмээний нуруун
дээрх өөх

Тарган тэмээний босоо
байдал.

Дасгал 2



А. Ертөнцийн гурвыг уншаарай.

Арван тавны сар нэг сайхан
Атар газрын цэцэг нэг сайхан
Аав ээжийн сургаал нэг сайхан

Худалч хүний нээрээ олон
Хуурамч хүний хөөрхий олон
Хуудуу хүний зөв олон



Б. Асуултад хариулж дэлгэрүүлэн яриарай.

Асуулт

- Яагаад аав ээжийн сургаал сайхан гэсэн бэ?
- Худалч хүний нээрээ олон гэсний учрыг тайлбарлаарай.
- Хуудуу хүн гэж ямар хүнийг хэлж байна вэ?



В. Зүйр үгсийн утгыг ярилцаарай. Яагаад алт, эрдэнэ гэж хэлсэн бэ?



Аавын сургаал алт
Ээжийн сургаал эрдэнэ



Аавын үгүйд ах нь аав
Ээжийн үгүйд эгч нь ээж



Г. Тодруулсан үгийг аль үгээр сольж болох вэ?

Эх хүний сэтгэл нэг **ариун**
Эх орончийн зүтгэл нэг **ариун**
Энх тайвны үйлс нэг **ариун**

Солих үг: цэвэр, дагшин, сайхан



Д. Үгийг зөв дуудаж, өгүүлбэрийг гүйцээн бичээрэй.

ЭХ



ЭЭЖ

.... хүүний үрээ гэсэн сэтгэлээс
илүү зүйл үгүй.

ЭЭХ



ХАЛААХ

Талын шгинд гараа
..... дулаацуулав.

Дасгал 3



А. Эхийг уншаад асуултад хариулаарай.

Монгол үндэсний хувцас

Монгол үндэсний дээл хувцас бол монгол хүний онцлогийг харуулдаг юм. Монгол дээл хувцас нь Монгол орны цаг уур, хүмүүсийн эрхэлж буй мал аж ахуй, амьдралын хэв маягтай салшгүй холбоотой. Настай хүмүүс ихэвчлэн хүрэн, шар өнгийн дээл өмсдөг. Залуучууд голдуу хурц тод өнгийн дээл өмсдөг.



Үндэсний хувцас нь иж бүрэн байж цогц харагддаг. Монгол үндэсний хувцас болох малгай, дээл, хантааз, бүс, гутал нь өөр өөрийн гэсэн бэлгэдэлтэй байдаг. Үүнд:

- **Мандах төрийн малгай:** Хүний сайн сайхан явахыг бэлгэдсэн байна.
- **Тэгш төрийн дээл:** Хүний нуруу цэх, хараа дээгүүр явахыг бэлгэдсэн.
- **Бүтэх төрийн бүс:** Үргэлжид бэхлэн батжуулах, эвлүүлэх утгатай.
- **Хан төрийн хантааз:** Аливаа хүндэтгэл, ёслолд заавал өмсөх тул энэ хувцсыг хан төрийн хантааз гэдэг.
- **Түших төрийн гутал:** Хүний биеийн тулгуур болсон хөлийн өмсгөл, тулж түших, бат суурьтай явахыг бэлгэдсэн.

Асуулт

- Монгол дээл хувцасны онцлог юу вэ?
- Настай хүмүүс ихэвчлэн ямар өнгийн дээл өмсдөг вэ?
- Залуучууд ямар өнгийн дээл өмсдөг вэ?
- Монгол үндэсний хувцас нь юу юунаас бүрддэг вэ?



Б. Танилцуулгыг уншаад өгүүлбэрийг гүйцээж бичээрэй.

Ашиглах үгс: Мандах төрийн, тэгш төрийн, бүтэх төрийн, хан төрийн, түших төрийн

Монгол үндэсний хувцас нь..... малгай, дээл, бүс, хантааз, гутал нь өөр өөрийн гэсэн бэлгэдэлтэй байдаг.



В. Зураг болон түлхүүр үгийг ашиглан дээлийн тухай танилцуулан яриарай.

Хэзээ өмсдөг вэ?



Хэн өмсдөг вэ?

Улирал, цаг агаар

Өнгө, материал



Г. “Монгол дээл” сэдвээр танилцуулга сурталчилгаа бичээрэй.



Д. Дараах үгсийг ажиглая. Өнгөөр ялгасны учрыг тайлбарлан ярилцаарай.

Хатуугийн тэмдэг, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдье.

Нүүе	Харь - хар	Гэртээ харья	Малаа харья	Хүрье
Саная	Барь - бар	Гэрээ барья	Идэж барья	Өсье
Оөё	Зорь - зор	Холыг зорьё	Мод зорьё	хүсье

Гийгүүлэгчээр төгссөн эр үгэнд “я”, “ё”-г залгахдаа өмнө нь “ь”, эм үгэнд “е”-г залгахдаа өмнө нь “ь” бичнэ.

Жишээ нь: явья, бодъё, хүсье

Эгшгээр болон зөөлний тэмдгээр төгссөн үгэнд “я, е, ё”-г шууд залгаж бичнэ.

Жишээ нь: угаая, хүлээе, больё



Е. Үгийн утгыг ялгасан өгүүлбэрийг гүйцээн бичээрэй.

бэлэг



талархаж өгөх зүйл

Шинэ жилээр өвлийн өвгөн ирж хүүхдүүдэд өгдөг.

бэлгэ



шинж тэмдэг

Соёмбо бол Монгол төрийн тэмдэг юм.

Дасгал 4



А. Анхааралтай уншаарай.

Гурван охин

Эрт урьд цагт гурван охинтой эмэгтэй амьдардаг байжээ. Тэр гурван охиноо хооллож, хувцаслахын тулд өдөр шөнөгүй ажиллана. Охид нь өсөж том болоод гэрээсээ явцгаагаад хэдэн жил өнгөрчээ.



Ээж нь хүнд өвчтэй болж, охид руугаа хэл хүргэхээр хэрмийг явуулав. Хамгийн том охин нь гунигтай мэдээг сонсоод:

- Би явмаар байгаа боловч, үнээгээ саах хэрэгтэй гэв.

Хэрэм хоёр дахь охин дээр очоод хэлтэл:

- Би явмаар байгаа боловч, дээл оёод завгүй байна гэв.

Отгон охин нь гурил зуурч байхад хэрэм очив. Охин нь юу ч хэлэлгүй, гараа ч арчилгүй ээж рүүгээ гүйлээ.

Ээж дээрээ ирсэн отгон охин нь ээжийнхээ амьдралын сүүлчийн мөчид хамтдаа байж, ээжийгээ асран халамжилжээ.

Ээж нь “Хайрт охин минь, хүмүүст үргэлж баяр баясгалан авчирч байгаарай” гэж захиж гэнэ. Ээжийнхээ ерөөлөөр отгон охин нь аз жаргалтай, урт удаан амьдарчээ.



Б. Гурван охин юу хийж байсан бэ? Өгүүлбэр болгон бичээрэй.

гурил зуурч байсан

Том охин

дээл оёж байсан

Отгон охин

үнээ сааж байсан

Бага охин



В. Цэгийн оронд нөхөж дэвтэрээ бичээрэй.

сайн

муу


Үр хүүхэд нь эцэг эхийгээ асарч халамжлах нь үйл юм.



Г. Хэн ээжийгээ асрахаар очсон бэ? Дэлгэрүүлж бичээрэй.



Д. Зургийг зөв дараалалд оруулж, үлгэрийн үйл явдлыг яриарай.



Е. Чи гурван охины аль нь баймаар байна? Амьдралдаа хийсэн хамгийн сайн үйлийнхээ талаар бичээрэй.



Ё. Үгийн утгыг ялгасан өгүүлбэрийг гүйцээн бичээрэй.

ТҮВШИН



ХЭМЖЭЭ

Таван Богд уул далайн
4374 метрийн өндөрт оршдог.

ТӨВШИН




зан төлөв

Манай хөри Батаа төлөв
..... зантай хүн.

Дасгал 5



А.Урилгыг уншаад бүтцийг ярилцаарай.



Б.Урилга бичих дарааллыг уншаарай.

1. Хэнийг урихаа бичнэ.


2. Юунд урихаа бичнэ.

3. Хаана, хэзээ ирэхийг бичнэ.

4. Хэн урьсныг бичнэ.



В. Хулангийн бичсэн төрсөн өдрийн урилгыг уншаад алдааг засаж бичээрэй.





Г. “Хүрэлцэн ирэхийг” гэдэг үгийг тохирох үгээр сольж бичээрэй.

*Хүндэт М. Эрдэнэ-Ошир таныг
Ерөнхий Боловсролын Сургуулийн суралгчдын
дунд зохион байгуулах “Цаасан урлал”-ын
үзэсгэлэнгийн нээлтэд **морилон ирэхийг** урья.*

Нээлтийн ажиллагаа:
2022 оны 10-р сарын 14-нд 10.00 цагт
“Хүүхдийн урлан бүтээх төв”-д болно

СУРГУУЛИЙН ЗАХИРГАА

оролцохыг
саатахыг
морилохыг
залрахыг



Д. “Нээлтэд” гэдэг үгийг өгөгдсөн үгсээр солин уншаарай.

*Хүндэт Х.Төрэл таныг
Ерөнхий Боловсролын Сургуулийн суралгчдын
дунд зохион байгуулах “Цаасан урлал”-ын
үзэсгэлэнгийн **нээлтэд** морилон ирэхийг урья.*

Нээлтийн ажиллагаа:
2022 оны 10-р сарын 14-нд 10 цагт
“Хүүхдийн урлан бүтээх төв”-д болно.

СУРГУУЛИЙН ЗАХИРГАА

сургалтад
баярт
цайллагад
нэвтрүүлэгт
уралдаанд



Е. Дотно найзаа төрсөн өдрийн баяртаа урьсан урилга бичээрэй.

Дасгал 6



А. Шүлгийн өргөлт, зогсолтыг тэмдэглэн хуулж бичээрэй. Бичсэнээ уран уншаарай.

Монгол Ухаан

Хар ус самардаггүй
Хаалга алдалж зогсдоггүй
Хайч ангайлгаж тавьдаггүй
Хайлган Монгол ухаан



Сав хоосон буцаадаггүй
Санаснаа биелсэнд тооцдоггүй
Сар өдрийг товлодоггүй
Саруул Монгол ухаан
Урган дээгүүр алхдаггүй
Усанд ам гардаггүй
Утас зангидаж өгдөггүй
Уужим Монгол ухаан ...



Ч.Эрдэнэбаатар



Б. Шүлгийн гол утга санааг багш болон ангийнхантайгаа ярилцаарай.



В. Ангийн дүрэмтэйгээ холбон ангид хийхийг хориглох зүйлсийг жагсаан бичээрэй.

Жишээлбэл: Хаалга онгорхой орхихгүй.



Г. Дараах үгсийг толь бичиг ашиглан утгыг тайлбарлан бичээрэй.

хайлган

саруул

уужим



Д. Үгийн утгыг ялгасан өгүүлбэрийг гүйцээн бичээрэй.

самар



хуш модны үр жимс

Энэ жимс жимс элбэг
ургажээ.

самар



шингэн зүйлийг
бага багаар асгах

..... цай
алттай.



А. Шүлгийн хэлэхэд хэцүү үгсийг давтан хэлж уншаарай.

ГУРВАН БААТАР

Баллуур

Баллуур баллуур
 Балласаар балласаар
 Байдаг бие нь
 Багассаар багассаар
 Алдааг минь
 Арилгасаар арилгасаар
 Зөрүүг минь
 Зөвтгөсөөр зөвтгөсөөр
 Ээ!
 Бүтэн биеэ дуусгалаа
 Бүхнээ надад зориуллаа
 Байнга сурахад тусаллаа
 Баатарлаг чамдаа баярлалаа.



Харандаа

Харандаа харандаа
 Хорогдсоор хорогдсоор
 Хамаг бие нь
 Барагдсаар барагдсаар
 Үсэг тоонууд
 Бичсээр бичсээр
 Үзсэн харсныг минь
 Зурсаар зурсаар
 Ээ!
 Нарийн биеэ дуусгалаа
 Надад бүхнээ зориуллаа
 Эрдэм сурахад тусаллаа
 Эрэлхэг чамдаа баярлалаа.



Саван

Саван саван
 Илэгдсээр илэгдсээр
 Сайхан бие нь
 Элэгдсээр элэгдсээр
 Халтар хултраас
 салгасаар салгасаар
 Хамгаас хөөрхөн
 болгосоор болгосоор
 Ээ!
 Нандин биеэ дуусгалаа
 Надад бүхнээ зориуллаа
 Цэвэрч явахад тусаллаа
 Чин зүрхнээс баярлалаа.



Асуулт



- Яагаад “Гурван баатар” гэж нэрлэв?
- Яагаад баллуурт “Баатарлаг чамдаа баярлалаа” гэж хэлсэн бэ?
- Яагаад харандаанд “Эрэлхэг чамдаа баярлалаа” гэж хэлсэн бэ?
- Яагаад саванд “Чин зүрхнээсээ баярлалаа” гэж хэлсэн бэ?



Б. Зургийг ажиглаад үгийн утыг тайлбарлаж бичээрэй.

багс



багас, хорогд



хорогд



В. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй

Баатар _____ хашаа будлаа. (багасаар, багсаар)

Өлгий хотод үүл _____, бороо орохгүй. (багсана, багасна)

Болор бид хоёр борооноос _____ саравчин доор зогсов. (хоргодож, хорогдож)

Улаан номд тоо толгой нь _____ буй амьтдыг оруулдаг. (хоргодож, хорогдож)



Г. Үгсийг зөв байрлуулан өгүүлбэр бүтээгээрэй.

арилгаж,

зөв

найз минь

алдааг

болгодог.

Баллуур

зөрүүг

үсэг

тоонууд

найз минь

үзсэн

харсныг минь

зурдаг

Харандаа

бичиж,

халтраас

найз минь

салгаж,

болгодог.

Саван

хамгаас

хөөрхөн



Д. Эрдэм ном сурахад тань тусалдаг “баатрууд”-аа нэрлэн бичээрэй. Нэгийг нь сонгож түүнд зориулсан шүлэг зохиогоорой.



Е. Үгийн утыг ялгасан өгүүлбэрийг гүйцээн бичээрэй.

ил



энхрийлж таалах

Эзэж “сайн охин шүү” гээд миний үсийг

эл



хуучирч муудах

Өвөөгийн авдар хуучирчээ.

Дасгал 2



А. Уншаад асуултад хариулаарай.

Тогоруу



Урьд цагт нэгэн малчин эр малаа хариулж явав. Тэгээд хэсэг тогоруу байхыг хараад хөгжмөө гаргаж, дуулж хуурджээ. Гэтэл тогоруунууд дээгүүр нь эргэлдэн нисэж байснаа доошлон бууж, дор дороо үсрэн эргэлдэж эхэлжээ. Түүнийг харсан малчин эр **урамшин**, улам сайхнаар дуулж, хөгжимдөхөд тогоруунууд бүр дэргэд нь ирэн бүжиглэсэн гэдэг. Тогоруу шувууны ийнхүү **товшин эргэлдэх хөдөлгөөнийг** зарим хүн “тогорууны бүжиг” гэдэг.

Асуулт

- Малчин эр юу харсан бэ?
- Малчин эр юу хийсэн бэ?
- Малчин эр хөгжим тоглоход тогоруунууд ямар үйлдэл хийсэн бэ?



Б. Шувуудын нэрийг бичээрэй. Тогоруу шувууг дэвтэртээ зурж, гадаад төрхийг дүрсэлж бичээрэй.



В. Тодруулсан үгсийн утгыг ярилцаарай.



Г. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж, тогорууны тухай танилцуулга бичээрэй.

Ашиглах үг: товшин эргэлдэж, нуур, урт хошуутай, тогорууны бүжиг, урт хөлтэй



Манай аймгийн тогоруу шувуу элбэг
байдаг. Тогоруу, сайхан шувуу.

Хөгжмийн аянд бүжиглэдэг.

Үүнийг гэдэг

Дасгал 3



А. Уншаад асуултад хариулж бичээрэй.

Бүргэдчин охин

Дэлхий дахинд “Бүргэдчин охин” нэрээр алдаршсан Н.Айшолпаны амьдралаас сэдэвлэн бүтээсэн “Бүргэдтэй анчин” кино нь олон улсын наадамд түрүүлсэн юм.



2014 онд Израйлын гэрэл зурагчин монголд ирж бүргэдийн баярт оролцоходоо Айшолпаны зургийг хальсанд буулгажээ. Зургийг харсан найруулагч Отта Веллад кино хийх санаа төрж, даруй Монголд ирж охины гэр бүлийнхэнд санал тавьсан байна.

Арван гуравхан настай Айшолпан бүргэдээр ан хийх соёлыг өвлөн яваа анхны эмэгтэй бүргэдчин юм. Тэрээр тавин хэмийн хүйтэнд найман цагийн турш ан хийдэг. Гурван жилийн дотор арван дөрвөн үнэг агнаж, арьсаар нь малгай хийж өмссөн нь хахир хатуу өвлийг өнтэй давахад тусалдаг талаар кинонд өгүүлдэг юм.

Асуулт



- Яагаад бүргэдчин охин гэж нэрлэв?
- Охин ямар ан хийдэг байв?
- Тэсвэр хатуужилтай гэдгийг юу гэж дүрсэлсэн байна вэ?
- Айшолпан яагаад казахын ард түмний бахархалт охин болов?



Б. “-чин” дагавар залган үг бүтээж ангилж бичээрэй.

Адуу, тариа, үхэр, тэмээ, ногоо, барилга, хонь, үс, зураг, ямаа, гагнуур, хурга

малчин

ажилчин



В. “Бидний бахархал” сэдвээр эх зохион бичээрэй.



Г. Айшолпан охиныг бусдад сонирхолтой байдлаар тоочин танилцуулж яриарай. Дараах бүдүүвчийг ашиглана уу.

Гадаад төрх 

Дотоод шинж 

Онцлог шинж 

Дүгнэлт 



Д. Нөхцөлийг залган бичихдээ гээгдэх ба гээгдэхгүй эгшгийн дүрэмтэй эсэхээр нь ангилж бичээрэй.

амьдрал+аас=
охин+ы=

бүргэд+ийн=
бүргэд+ээр=

зураг+ийг=
давах+д=

Гээгдэх эгшгийн дүрэмтэй үг

Гээгдэхгүй эгшгийн дүрэмтэй үг

Дасгал 4



А. Шүлгийг уншаад асуултад хариулаарай.

Монгол хүүхдийн эрхэмлэх есөн зүйл

Би эх орондоо хайртай эрхэмсэг Монгол хүүхэд
Би ээж аавдаа ачлалтай хүнлэг Монгол хүүхэд
Би эрүүл чийрэг биетэй эрэмгий Монгол хүүхэд
Би эрдэм номд хичээнгүй зорилготой Монгол хүүхэд
Би хатуу бэрхээс халирдаггүй өөдрөг Монгол хүүхэд
Би үнэнч шударгыг дээдэлдэг хариуцлагатай Монгол хүүхэд
Би ажил хөдөлмөрт шамдангуй бүтээлч Монгол хүүхэд
Би ахан дүүсээ хүндэлдэг ухаалаг Монгол хүүхэд
Би ардын уламжлалаа дээдэлдэг удамт Монгол хүүхэд

Асуулт

- Эрхэмлэх зүйлийн ямар шинж чанар чамд байдаг вэ?
- Яагаад мөр бүр “Би”-ээр эхэлж “хүүхэд” гэсэн үгээр төгссөн юм бол? Багшаасаа асууж ярилцаарай.
- Шүлгийн бүтэц, хэлбэрийг дуурайн “Сурагч миний эрхэмлэх зүйл” шүлэг зохион бичнэ үү.
- Зохиосон шүлгээ ангийнхандаа уншиж өгч, ярилцаарай.



Б. Ойролцоо утгатай үгийг холбоо үг болгон бичээрэй.



В. Найзуудынхаа зохиосон шүлгээс ойлгомжгүй үгийг толь бичиг ашиглан утгыг мэдэж аваарай.



Г. Үгийн утгыг ялгасан өгүүлбэрийг гүйцээн бичээрэй.

шударга



зан чанар

Би үнэнч
зантай хүнийг хүндэлдэг.

шударга



хөгжмийн зэмсэг

Энч хөгжмөөр
хөгжимдөж суулаа.

МОНГОЛ ХЭЛ IV ГАРЫН АВЛАГА

Хос хэлний сургалттай ерөнхий боловсролын
сургуулийн 4 дүгээр ангид судална.

Зохиогчийн баг

Ахлагч:

Ж.Гэрэлмаа

Гишүүд:

А.Еркегүл

З.Жанаргүл

Б.Гүлжан

Редактор:

Д.Эрдэнэсан

Х.Султанмурат

Зураач:

Н.Буян

Хэвлэлийн эх бэлтгэгч:

С.Алтантуяа

Формат: 84x108/16

Офсет хэвлэл. Офсет хэвлэлийн цаас. 80гр/м²

Хэвлэлийн хуудас: 10х.х

Хэвлэлийн эхийг “Содпресс” ХХК-д бэлтгэж,
“Содпресс” ХХК-д 2480 хувь хэвлэв.

